“НЭМЭЛТ ТОВХИМОЛ” БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын

УДИРДАМЖ

World Health Organization
Western Pacific Region

UNESCO

ILO

IDC

ДЭМБ-ын Номын сангийн каталоги
Хамт Олонд Түшиглэн Сэргээн Засах Хандлага: ХОТСЗ хандлагын Удирдамж

1.Сэргээн засалт. 2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн. 3.Хамт олонд түшиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээ. 4.Эрүүл мэндийн бодлого. 5.Хүний эрх. 6.Нийгмийн шударга ёс. 7.Хэрэглэгчийн оролцоо. 8.Удирдамж. I.Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. II.НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Байгууллага. III.Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага. IV. Хөгжлийн бэрхшээл, Хөгжлийн олон улсын консорциум

ISBN 978 92 4154805 2 (NLM ангилал: WB 320)

© Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага 2010

Бүх эрх хадгалагдсан. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын хэвлэлийг WHO Press, World Health Organization, 20 Avenue, 1211 Geneva 27, Switzerland (tel: +41 22 791 3264; fax: +41 22 791 4857; e-mail: bookorder@who.int) -аас авч болно. ДЭМБ-ын хэвлэлийг орчуулах эсвэл дахин боловсруулж зарах эсвэл арилжааны бус байдлаар хэрэглэх алинд нь ч зөвшөөрөл авах ба ДЭМБ-ын Хэвлэлийн газарт дээр дурдсан хаягаар (fax: +41 22 791 4806; e-mail: permission@who.int) хандана.

Энэхүү хэвлэлийн дотоод агуулга нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын үзэл бодлыг илэрхийлэхгүй. Газрын зурган дээрх цэгэн зураас хилийг ойролцоогоор төлөөлсөн.

Үүнд дурдагдсан тухайн онцгойлсон компани эсвэл үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас зөвлөсөн эсвэл зөвшөөрсөн гэсэн үг биш.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага энэхүү хэвлэлд орж буй мэдээллийг баталгаажуулж бүх боломжит урьдчилан сэргийлэх аргуудыг авсан хэдий ч уг хэвлэлийг ямар нэгэн илэрхийлэл, зөвшөөрлийн баталгаагүйгээр тараасан болно. Орчуулгын хариуцлага болон уг материалыг ашиглах эрх нь уншигч танд буй. Үүнийг ашиглахад гарах ямар нэгэн хохирлыг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага хариуцахгүй.

Хэвлэлийн дизайн, загварыг Inis Communication

www.iniscommunication.com

Мальтад хэвлэв.

Энэхүү товхимлыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрөлтэйгөөр Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй" төслийн санхүүжилтээр 600 хувь хэвлэв.

СЗСҮТ

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Эрхүүгийн гудамж, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв
20-р салбар, Ш,х: №364
Утас:352423
Цахим шуудан: info@nrc.gov.mn
Цахим хуудас: www.nrc.gov.mn

АИФО

Холбоо барих хаяг:
АИФО байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
Улаанбаатар 210648, Ш,х:75
Утас: 70153058

Дэлхийн зөн

Холбоо барих хаяг:
Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, 15-р хороо, (133-70), Энхтайвны өргөн чөлөө, 49-р барилга, Соманг плаза, 4-р давхар, Улаанбаатар 15160,
Шуудангийн хайрцаг 705
Вэб: http://www.wvi.org/mongolia

Орчуулсан: Д. Тулгамаа, АИФО байгууллагын суурин төлөөлөгч, нийгмийн ухааны магистр, докторант

Хянасан: Л.Энхбуянт, АИФО байгууллагын менежер, нийгмийн ухааны магистр, докторант

Хянасан: С.Баярбат, СЗСҮТ-ийн Бодлогын хэрэгжилт, нийгмийн оролцооны хэлтсийн дарга, хууль зүйн ухааны магистр

Хянасан: Г.Түвшинжаргал, СЗСҮТ-ийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Жавхлан, СЗСҮТ-ийн мэдээлэл технологийн мэргэжилтэн

ХАМТ ОЛОНД ТҮШИГЛЭН СЭРГЭЭН ЗАСАХ ХАНДЛАГЫН УДИРДАМЖ

НЭМЭЛТ ТОВХИМОЛ

Агуулга:

Танилцуулга.....05

Хамт олонд түшиглэсэн сэргээн
засалт ба сэтгэцийн эрүүл мэнд.....06

Хамт олонд түшиглэсэн
сэргээн засалт ба ХДХВ/ДОХ.....24

Хамт олонд түшиглэсэн
сэргээн засалт ба уяман.....36

Хамт олонд түшиглэсэн
сэргээн засалт ба хүн төрөлхтөний хямрал.....50

Танилцуулга

Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын (ХОТСЗ) удирдамжийг хөгжлийн бэрхшээлийн бүх бүлэг хүмүүст хэрэглэж болох боловч ХОТСЗ хөтөлбөрийн түүхэндээ хөндөөгүй орхисон сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд, ХДХВ/ДОХ, уяман болон хүн төрөлхтний гамшиг зэрэг сэдвүүдээр нэмэлт товхимол гаргах хэрэгцээ байна. Эдгээр асуудлуудыг урд өмнө нь хөндөж байгаагүй хэд хэдэн шалтгаан байж болно. ХОТСЗ хөтөлбөрт тухайн үедээ халдварт саа болон бусад халдварт өвчин тэргүүлэх байр суурь эзэлж, мэргэжилтнүүдийг тухайлбал хөдөлгөөн засалчийг хамруулж байснаас үүдэн хөтөлбөр хөдөлгөөний бэрхшээлд илүү анхаарал тавьдаг байсан. Харин өнөөдөр бол асуудал өөр болсон. Буруу ойлголт, ялгаварлан гадуурхалт байсаар байгаа өнөө цагт ХОТСЗ хөтөлбөр шинэ тулгарч буй асуудлуудад хэрхэн хандах талаар хөтөлбөрийн менежерүүдийн мэдлэг дутмаг байж болох юм. Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээллүүд нь сүүлийн 30 жилийн турш хувьсан өөрчлөгдөж өнөөдөр мэддэг болсон мэдээллүүдийг энэхүү ХОТСЗ хандлагын удирдамжаар танилцуулж байгаа билээ. ХОТСЗ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн бүхий л үйл ажиллагаанд хамруулж, ялгаварлан гадуурхахгүй байх НҮБ-н Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн зарчмуудыг анхааралдаа авсан хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх стратеги юм. Тиймээс урд өмнө нь хөндөж байгаагүй асуудлууд болох сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, ХДХВ/ДОХ, уяман болон хүн төрөлхтөний хямрал зэрэг сэдвүүдийг анхааралдаа авч, зохих арга хэмжээг авах нь чухал юм. Энэхүү товхимолд дээрх дөрвөн сэдвийг сонгосон боловч хамт олны дунд ихээр тохиолддог, энэхүү удирдамжийг ирээдүйд дахин хянан боловсруулахдаа өөр бусад (ХОТСЗ ба хүүхдүүд, ХОТСЗ ба насжилт) асуудлуудыг авч үзэх шаардлагатай.

Хамт олонд түшиглэсэн сэргээн засалт ба сэтгэцийн эрүүл мэнд

Танилцуулга

Сэтгэцийн эрүүл мэнд гэдэг бол хүн өөрийнхөө амьдралын энгийн стрессийг давж, үр бүтээлтэй ажиллаж, хамт олонтойгоо хамтран ажиллаж, өөрийнхөө чадварыг таньж сайн сайхан байхыг хэлнэ. Сэтгэцийн эрүүл мэнд нь хувь хүн, гэр бүл, хамт олон, нийгмийг сайн сайхан байлгахад нэн чухал ерөнхий эрүүл мэндийн салшгүй нэгэн хэсэг нь юм.
Сэтгэцийн эрүүл мэнд нь хөгжлийн хөтөлбөр болон ерөнхий нийгэмд доогур байр суурьтай байдаг. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар мэдлэг дутмаг, буруу ойлголт газар авсан, ялгавардан гадуурхалт, хязгаарлалт өргөн тархсан байдаг. Хамт олон бүрт тусгаарлагдсан, орхигдсон, үндсэн эрхээ эдэлж чадахгүй байгаа сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенци нь “сэтгэцийн бэрхшээлтэй” хүмүүсийг хамруулахыг дараах байдлаар онцолсон: (i) бүх эрх болон үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн, тэгш эдлүүлэх; (ii) тэдэнд иргэний, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын орчинд жижил боломж олгож, тэднийг оролцуулах.
Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай байгаа хүмүүс, ялангуяа хөгжил буурай оронд амьдарч байгаа бол, эрүүл мэндийн үйлчилгээ, тусламж дэмжлэг хүртэх нь асар хязгаарлагдмал байдаг. Мөн түүхийн хувьд ХОТСЗ хөтөлбөр эдгээр хүмүүсийг үйл ажиллагаандаа хамруулдаггүй байсан хэдий ч Энэтхэгийн хөдөө газар архаг шизофрения өвчтэй хүмүүсийг ХОТСЗ хөтөлбөртөө харуулсныг харахад энэ хөтөлбөр сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст эерэг үр дүнд хүрч болдог гэдгийг харуулсан. Ялангуяа нөөц бололцоо дутмаг нөхцөлд үр дүнд хүрдэгийг баталсан.

Энэхүү ХОТСЗ хандлагын Удирдамж нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай төдийгүй бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамаатай бөгөөд сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст тулгардаг ихэнх асуудлууд бусад төрлийн бэрхшээлтэй хүмүүст ч гэсэн ижил тулгардаг учраас тэдэнд мөн бусад бүрэлдэхүүн хэсгүүд ч гэсэн хамаатай. Гэхдээ энэ хэсэг нь ХОТСЗ хөтөлбөр сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүстэй ажиллах туршлага хязгаарлагдмал байгаа учир тэдгээр хүмүүсийг ХОТСЗ хөтөлбөрийн үйл ажиллагаанд хамруулахад нэмэлт удирдамж өгөхөд оршино.

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс гэж ярихаар маш олон нэр томьёо байдаг учраас хэлэх хэллэгээ буруу сонгож будлих явдал байж болдог, тухайлбал сэтгэцийн өвчин, сэтгэцийн ноцтой өвчин, сэтгэцийн эмх замбараагүй байдал, сэтгэцийн эмгэг, согог, сэтгэцийн эрүүл мэндийн нөхцөл, зан үйлийн эмгэг, солиорол, сэтгэцийн өвчин-эрүүл мэнд, сэтгэцийн өвчин, сэтгэц нийгмийн бэрхшээлээс амьд үлдэгсэд, хэрэглэгчид гэх мэт. Энэ хэсэгт орчуулахад хялбар учраас “сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс” гэсэн нэр томьёог ашигласан. Үүнд архаг сэтгэл гутрал, шизофрения, хоёр туйлтай эмгэг, бодисонд донтох эмгэг зэрэг нөхцөл байдалтай хүмүүсийг хамруулсан.

Жишээ 1 Япон

Кокорон

2002 онд Японы Фукушима мужийн хотын дарга, хамт олны сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд болон бусад хамт олны гишүүд хамтарч ашгийн бус Кокорон нэртэй байгууллагыг байгуулсан билээ. Кокорон гэдэг нь зүрх, сэтгэл гэсэн утгатай үг учир энэхүү нэрийг нутгийн олон сонгожээ. Кокорон өөрийн бүсийн ядууралтай тэмцэж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон бусад бүх хүмүүс ижил тэгш эрхтэй, аюулгүй, эрхэм зэргээ хүндлүүлж амьдрахад нь туслаж, дэмжих зорилготойгоор хамт олны хөгжилд анхаарлаа хандуулсан.

Эхэндээ Кокорон гурван жилийн туршид цуврал сургалт, семинар зохион байгуулж нутгийн хүмүүс, өөрийн байгууллагын ажилтнууд болон удирдах зөвлөлийн гишүүдийнхээ мэдлэгийг дээшлүүлж, чадавхийг бэхжүүлэхэд анхаарлаа хандуулсан. Мужийн захиргаа, орон нутгийн хамт олны дэмжлэгтэйгээр семинар зохион байгуулах сургагч багш нарыг өөр хөгжлийн салбараас урьж авчирсан. Кокорон хэд хэдэн орлого нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулсан. Тухайн орон нутагт орлогын гол эх үүсвэр нь хөдөө аж ахуй учир Кокорон энэ салбарт олон үйл ажиллагаа хийхээр шийдвэрлэсэн. Кокорон ногоо, мөөг, жимс, саки зэрэг орон нутгийн бүтээгдэхүүн зардаг, мөн өдрийн хоол, амттан хүргэдэг Кокораяа нэтрэй кафе болон дэлгүүр нээсэн. Кокораяаг сонин, телевизээр сурталчилсны дараа хүмүүсийн уулздаг алдартай газар болсон юм.

2004 оны 3-р сард Кокорон сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст туслах зорилгоор Изүмизаки тосгонд хамт олны төв байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуа сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс хөгжлийн үйл ажиллагаанаас гадуур байдгийг Кокорон мэдэж авч, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдэд зөвлөгөө өгөх, амьдрах орон байр, ажлын байран дээрх сургалт, сургалт болон дэмжлэг үзүүлэх гэх мэт төрөл бүрийн дэмжлэгийг үзүүлсэн. Кокороны төрөл бүрийн орлого нэмэгдүүлэх ажлын үр дүнд сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай олон хүмүүс нийгэмшиж, тэд Кокораяагийн болон бусад бизнесийн байгууллагын гол ажиллах хүч болсон. Тэдний амьдрал өөрчлөгдсөн. Тэд сэтгэцийн эмнэлэгт хэвтэж, тусгаарлагдахаа больсон, тэд эвсэг, найртай орчин үүсгэж чаддаг болсон, тэдний эрүүл мэнд, нийгэм эдийн засгийн нөхцөл сайжирсан, мөн тэд бие дааж, сэтгэл ханамжийн мэдрэмжтэй болсон.

Кокорон, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс хамт олны амьдралын салшгүй нэг хэсэг болж чадсан, хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх хандлагын сайн жишээ юм.

Зорилго

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг хамт олны амьдралын бүхий л зүйлд хамруулж, оролцуулахын тулд тэдэнд туслах.

ХОТСЗ-ын үүрэг

ХОТСЗ хөтөлбөрийн үүрэг нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих, тэднийг илааршихад туслах, тэднийг гэр бүл болон хамт олон дотор нь хамруулан оролцуулахад нь туслана.

Хүсч буй үр дүн

- Сэтгэцийн эрүүл мэнд нь бүх хамт олны гишүүдээр үнэлэгддэг ба хамт олны хөгжилд хүлээн зөвшөөрөгдсөн шаардлага шиг байдаг. .
- ХОТСЗ хөтөлбөрт сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг хамруулна.
- Хамт олон сэтгэцийн эрүүл мэндийн талаар мэдлэгтэй болж, тэдгээр хүмүүсийг ялгаварлан гадуурхалт, буруу ойлголт нь багасна.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг илаарших явцад тус дөхөм болохын тулд эмнэлэг, сэтгэл зүй, нийгэм, эдийн засгийн үйлчилгээг хүртэж чадна.
- Гэр бүлийн гишүүдэд сэтгэл хөдлөлийн болон практик дэмжлэг үзүүлнэ.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс эрх мэдэлжиж, гэр бүл болон хамт олны амьдралд оролцох оролцоо нь ихэснэ.

Жишээ 2 Монгол

Хамт олонд түшиглэсэн сэтгэцийн эрүүл мэнд төсөл хэрэгжсэн нь

2011 оны 12-р сарын 1-нээс 2014 оны 11-р сарын 30-ны хооронд гурван жилийн хугацаанд Европын Холбоо, Италийн АИФО төрийн бус байгууллагын хамтын санхүүжилтээр ”Дунд болон доогуур орлоготой орнуудад хамт олонд түшиглэсэн сэтгэцийн эрүүл мэнд” туршилтын төслийг 5 оронд (Монгол, Индонези, Бразил, Либерия, Египет) хэрэгжүүлсэн. Монгол улсын Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв уг төсөл дээр түншлэгчээр хамтран ажилласан. Төсөл Улаанбаатар хотын 6 дүүрэгт хэрэгжсэн. Төслийн хүрээнд “Хамт олонд түшиглэсэн сэтгэцийн эрүүл мэнд” сэдэвт сургалт болон хүний эрхийн сургалтуудыг зохион байгуулсан. Сургалтанд өрхийн эмч, сэтгэцийн эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтэн, эрүүл мэндийн 2 дахь шатлалд ажиллаж буй сэтгэцийн эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, үйлчлүүлэгч, ар гэрийнхэн, ХОТСЗ хөтөлбөрийн зохицуулагч, ТББ-ын төлөөлөгч, хүний эрхийн мэргэжилтэн нийт 316 хүн хамрагдсан. Сургалтаар сэтгэцийн эрүүл мэндийн тухай, зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгүүд (сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, ядаргаа, цочмог болон архаг солиорох эмгэгүүд, тайлбарлаж боломгүй биеийн эмгэгүүд, өвчирхөх эмгэг, сэтгэлийн шалтгаан тэмгэгүүд, сэтгэлийн хөдөлгөөний эмгэгүүд, архинд донтох эмгэг, тамхинд донтох эмгэг, мансууруулах бодисын хэрэглээтэй холбоотой үүсэх эмгэг), үйлчлүүлэгчтэй харилцах харилцаа, ярилцлага хийх, сэтгэц нөлөөт эмийн эмчилгээний талаар хичээлүүд заагдсан. Мөн хамт олонд түшиглэсэн сэргээн засалтын удирдамж, хандлага, сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрхийн талаар хичээлүүд орсон. Сургалт зохион байгуулсны үр дүнд сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн мэддэг байсан мэдлэгийг өрхийн эмч нарт зааж өгснөөр төвлөрөлийг сааруулахад чухал ач холбогдолтой болсон.

Мөн сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн өөрөө өөртөө туслах бүлгийг Улаанбаатар хотын 6 дүүрэг, СЭМҮТ дээр тус тус байгуулсан. Нийт 8 бүлэг байгуулагдан ажиллаж байна. Энэ жилээс эхлэн ӨӨТБ-үүд орлого олох жижиг төслүүдийг хэрэгжүүлж эхэлж байна. Тухайлбал: Сонгинохойрхон дүүргийн ӨӨТБ эмнэлгийн аюулгүй хайрцгийг хийж дүүргийн өрхийн эмнэлгүүддээ зарж борлуулахаар ажиллаж байна. Баянгол дүүргийн ӨӨТБ ноосон оймс, бээлий хийж байна. Налайх дүүргийн ӨӨТБ орны цагаан даавуу оёж байна. Сүхбаатар дүүргийн ӨӨТБ ажлын бээлий оёж байна. Хан-Уул дүүргийн ӨӨТБ хаягдал ундааны саваар сандал, шүүр хийж байна. Гэх мэтээр ӨӨТБ-т хамрагдаж байгаа сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг тодорхой хэмжээгээр ажилтай, найз нөхөдтэй болгоход анхаарлаа хандуулж байна. Төслийн үр дүнд сэтгэцийн эмгэгтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд нийгмийн ажилд идвэхтэй оролцож, сэтгэгдэлээ хуваалцаж, найз нөхдүүд болсон.

Гол ойлголтууд

Сэтгэцийн эрүүл мэнд ба хамт олны хөгжил

Ядуурал сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай холбоотой байдаг (Танилцуулга товхимол, Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсгийг үзнэ үү) – энэ нь харилцан шалтгаан, үр дагавар аль аль нь болдог. Ядуу нөхцөлд амьдарч байгаа хүмүүс

орчин, сэтгэл зүйн стресс (хүчирхийлэл, нөөц бололцоонд хүрэх хүртээмж хязгаарлагдмал, ажилгүйдэл, нийгмээс тусгаарлах, аюултай байдал гэх мэт)-т асар их хэмжээгээр орж байдаг. Ингэснээр сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд орох эрсдэл нь ихэсдэг. Ядуурал одоо байгаа сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг улам дордуулж, итгэл найдваргүй, эрх мэдэлгүй, хүчгүй гэдэг мэдрэмж нь илүү ихэсдэг. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс ядууралд илүү өртдөг, учир нь тэдэнд боловсролтой, ажилтай, орон гэртэй байх зэрэгт саад бэрхшээл илүү их тулгардаг. Ийм байдлаар тэд хатуу ширүүн нөхцөл байдалтай байнга тулгарч байдаг.

Сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулахад хамт олон, эдийн засгийн хөгжлийг ашиглаж болно. Ядуурлыг бууруулах, эдийн засгийн хувьд бие даах, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх, өлмөн зэлмэн байдлыг багасгах, бичиг үсэгтэй болгох, боловсрол эзэмшүүлэх, анхаарлаас гадуур байгаа хүмүүсийг эрх мэдэлжүүлэх зэрэг хамт олны хөгжлийн хөтөлбөрүүд нь сэтгэцийн эрүүл мэндийг дэмжиж, сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаас урьдчилан сэргийлэхэд хувь нэмрээ оруулна.

Сэтгэцийн сайн эрүүл мэндтэй хүмүүс асуудлаа илүү сайн шийдэж, нийгмийн сүлжээ байгуулж, бие биедээ харилцан дэмжлэг үзүүлж чаддаг. Хамт олны хөгжлийн нэг хэсэг болох ХОТСЗ нь бүх хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэндэд анхаарал тавьж, энэ явцдаа хамт олны удирдагч, гишүүдийг оролцуулах ёстой. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс хамт олны хөгжилд хувь нэмрээ оруулж чадна.

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын талаарх нийтлэг цуу яриа

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын талаар нийгэм маш хязгаарлагдмал ойлголттой байдаг, тиймээс олон цуу яриа гаргасан байдаг. Дараах нийтлэг цуу яриа байдаг:

- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудал бол ер бусын. Ер нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудал бол бүх насны, шашин, улс орон, хамт олонд байдаг. Ойролцоогоор 450 сая хүмүүс сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай байдаг гэдэг тооцоо байдаг ба дөрвөн хүний нэг нь амьдралынхаа аль нэг хэсэгт энэ асуудалд өртсөн байдаг.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс, ялангуяа сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүс, тухайлбал шизофрения өвчтэй хүмүүс огцом ширүүн, тэдний бусдын дунд амьдруулбал бусдын аюулгүй байдалд аюул үүсгэдэг. Үнэндээ сэтгэцийн асуудалтай хүмүүсийн ихэнх нь огцом ширүүн биш байдаг. Цөөн хэдэн хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудал хүчирхийллийн эрсдэл нь нэмэгддэг. Тэгэхдээ хүчирхийллийн эрсдэл нэмэлт хүчин зүйлүүдээс (бодисонд донтох, хувийн түүх, орчны стресс үүсгэдэг хүчин зүйлс) шалтгаалдаг. Сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүс огцом ширүүн байхаасаа илүү айсан, сандарсан, цөхөрсөн, бачимдсан байдалтай байдаг.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай харилцахад хэцүү, ийм хүмүүс хэзээ ч сайжрахгүй. Үнэндээ бол сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд хандах илүү үр дүнтэй аргууд байдаг ба эдгээр аргууд нь өөрийн шинж тэмдгээ хяналтан дор байлгаж, эсвэл бүрэн эдгэдэг.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг онцлог шинж чанарын сул тал бий болгодог. Үнэндээ бол сэтгэцийн эрүүл мэндийн асуудал бол биологийн, сэтгэл судлалын болон нийгмийн хүчин зүйлүүдийн бүтээгдэхүүн юм.

Буруу ойлголт ба ялгаварлан гадуурхалт

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийн талаарх буруу ойлголт болон ялгаварлан гадуурхалт маш өргөн тархсан байдаг ба энэ нь хувь хүн, орон гэр, гэр бүлийн амьдрал, ажил гээд амьдралын бүхий л салбарт нөлөөлж, тэр ч байтугай хүмүүс амьдралынхаа үндсэн стандартыг барих чадварт ч нөлөөлдөг. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс өөрт нь тохиолддог буруу ойлголт, ялгаварлан гадуурхалтай тулгарч, тэдний нөхцөл байдлыг илүү дордуулдаг гэж тодорхойлдог. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийн гэр бүлийн гишүүдийн ойлголт бас хязгаарлагдмал, хандлага хязгаарлагдмал, ялгаварлан гадуурхсан зан үйлтэй байдаг.

Буруу ойлголт цаашилбал өөрөө өөрийгөө буруу ойлгох, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүд нийгмийн сөрөг хандлагыг бий болгоход хүргэдэг. Тэд бусдын хэлж байгааг бодож, үнэмшиж эхэлдэг, ингэснээр өөрөө өөрийгөө буруутгах, өөртөө итгэх итгэлгүй болдог.

Буруу ойлголтоос болоод олон хүмүүс өөрсдийгөө нийгмийн сүлжээнээс тусгаарлаж, амьдралынхаа боломжийн давуу талыг эдэлж чаддаггүй. Үүнээс болоод нийгмээс тусгаарлагдах, ажилгүй, орлого багатай болж болно. Ялгаварлан гадуурхалт эсвэл өөрт тохиолдсон туршлагаасаа болоод олон хүмүүс өөрсдийнхөө сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг нууж, тусламж хүсэхээ больдог.

Хүний эрх

Олон оронд сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийн хүний эрх зөрчигддөг. Ихэнхдээ сэтгэцийн эмнэлэг дээр тэдний эрх зөрчигддөг: тохиромжтой бус, хортой, хөнөөлтэй, дорой асрамж, эмчилгээ, ариун биш, хүн амьдрахааргүй амьдралын нөхцөлд байлгах гэх мэт. Мөн нийгэм дотор сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс иргэний эрх чөлөөгөө эдэлж чаддаггүй, боловсрол эзэмших, ажил хөдөлмөр эрхлэх, орон гэртэй болох зэрэг хүртээмж нь хязгаарлагдмал байдаг.

Хүн бүр, мөн сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс ч ижил тэгш эрхтэй. Бүх олон улсын хүний эрхийн конвенциуд сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст хамаатай бөгөөд тэдний эрхийг тэгш, ялгаварлан гадуурхахгүй зарчмаар хамгаалах ёстой, тухайлбал Хүний эрхийн түгээмэл тунхаглал. Мөн сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст зориулсан тусгай конвенциуд ч байдаг, тухайлбал Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци.

Олон улсын хүний эрхийн стандартуудыг сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст нийцүүлэхийг баталгаажуулахын тулд улс орнуудад бодлого, хууль шаардлагатай, тиймээс сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг сайн сайхан байлгах, тэдний амьдралыг хамгаалж, дэмжиж, сайжруулахын тулд бүх хүмүүс хамтарч ажиллаж, үйл ажиллагаа хийж эхлэх хэрэгтэй.

Эрүүл мэндийн тусламж

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст ерөнхий болон тусгай эрүүл мэндийн тусламж шаардлагатай байж болно.

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын хувьд

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг илааршихад дэмжлэг үзүүлэх маш олон тооны эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээнүүд байдаг. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сэтгэцэд нөлөөлөх эмийн жор бичих (сэтгэцийн өвчний эсрэг, гутралын эсрэг, зан ааш тогтворжуулагч), сэтгэцийн эрүүл мэндийн нөхцөлтэй хамтарсан эмчилгээ зэрэг орно. Сэтгэл зүйн тусламж үйлчилгээнд дараах зүйлүүдийн нэг буюу түүнээс олон зүйлүүд хамрагдана: нөхцөл байдал болон эмчилгээний сонголтын талаарх боловсрол, зөвлөгөө өгөх, ганцаарчилсан эсвэл бүлгийн сэтгэцийн эмчилгээ, гэр бүлийн дэмжлэг гэх мэт.

Ихэнх соёлд сэтгэцийн эрүүл мэндийн ойлголт шашин, оюун санаа, ид шидийн итгэл үнэмшилтэй холбоотой байдаг. Тиймээс сүсэг бишрэлийн удирдагч болон нутгийн анагаах увидастан (илээч, бариач)-д нарт эхлээд ханддаг. Гэхдээ нутгийн анагаах увидастаны (илээч, бариач) зарим нэг тодорхой нийтлэг практикууд нь янз бүр байдаг гэдгийг мэдэх нь чухал – зарим эмчилгээний арга нь хортой хөнөөлтэй, харин зарим нь тийм биш байдаг. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд соёлын хувьд мэдрэг асуудлыг орон нутгийн анагаах уламжлалд анхаарч, туршлага солилцох, бие биеэ харилцан ойлголцох шаардлагатай.

Жишээ 3 Гана

Нутгийн анагаах увидастан (илээч, бариач) нартай түншлэх нь

Ганад сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийн 75 гаруй хувь нь эхлээд нутгийн анагаах увидастан (илээч, бариач) дээр очдог. Тиймээс сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдийг сайн сайхан байлгахын тулд нутгийн анагаах увидастантай ажиллах нь чухал байдаг.
“Үндсэн хэрэгцээ Гана” байгууллага Ганад сэтгэцийн эрүүл мэндийн нөхцөл байдалд дэвшил гаргаж, эерэг өөрчлөлт хийхийн тулд нутгийн анагаах увидастантай хамтарч ажилласан. Тэд Анагаах увидастануудын нийгэмлэгийн уулзалтыг зохион байгуулж, сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар, тухайлбал анагаах талаар баримжаа олгох сургалт зохион байгуулсан.

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд үр дүнтэй үйлчилгээг илрүүлсэн хэдий ч мэргэшсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь маш хязгаарлагдмал байдаг. Сэтгэцийн эмч, сувилагч, сэтгэл судлаач, нийгмийн ажилтнууд бага болон дунд орлоготой орнуудад дутмаг байгаа нь эмчилгээ хийх, тусламж үзүүлэхэд хамгийн гол саад бэрхшээл нь болдог. Тэдгээр хүмүүс нь байсан ч эмийн болон мэргэжлийн зөвлөгөөний төлбөр нь өндөр байдаг. Харин бага орлоготой орны хүмүүст уг хүртээмж нь хязгаарлагдмал байдаг.
Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст зориулсан мэргэшсэн эрүүл мэндийн үйлчилгээ байсан ч энэ нь үргэлж тохиромжтой биш байдаг. Сэтгэцийн өвчтэй хүмүүсийн эрх зөрчигдөж байдаг гэдгийг ихэнх орнуудад тэмдэглэсэн байдаг ба үүнд үндсэн хэрэгцээ болон хувийн байдлыг үгүйсгэсэн, бие бялдрын хувьд хоригдсон, ганцаар бөглүү амьдрах гэх мэтийг хамруулсан. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай олон хүмүүс сэтгэцийн эмнэлэгт хэвтэх, эмчлүүлэх, эмнэлгийн тусламж авах дургүй байдаг. Сэтгэцийн эрүүл мэндийн

мэргэжилтнүүд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хэрэглэгчид болон өмнө нь хэрэглэдэг байсан хүмүүстэй басамжилж, доромжилж харьцаж байгаа мэдрэмж тэдэнд үргэлж төрдөг, тэд өөрсдийнхөө нөхцөл байдлын талаар ямар ч мэдээлэл авдаггүй, мөн тэднийг өөрсдийнхөө амьдралд хариуцлага хүлээж, шийдвэр гаргаж чаддаггүй гэж үздэг.

Ерөнхий эрүүл мэндийн тусламж

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг бусад энгийн хүмүүстэй харьцуулахад тэдний бие өвдөх нь үргэлж өндөр байдаг. Тэд ихэнхдээ хэт таргалалт, цусны даралт ихсэх өвчин, чихрийн шижин гэх мэт асуудлуудтай байдаг. Шизофрения өвчтэй хүмүүс зүрх судасны өвчнөөр их өвчилдөг, мөн энэ нь бусад хүмүүстэй харьцуулахад илүү үхлийн шалтгаан болдог. Мөн тэд халдварт өвчин, амьсгалын өвчин, хавдрын зарим төрлүүд болон ХДХВ-ийн халдвар зэрэг өвчнөөр арай илүү өвчилдөг. Үүний шалтгаан нь сэтгэцийн эрүүл мэндийн онцгой асуудал (эмчилгээний үр нөлөө), тамхидалт, бие бялдрын хувьд идэвхгүй байх, эрүүл мэндийн тогтолцоо зэрэг эрүүл мэндийн зан үйлтэй холбоотой хүчин зүйлүүд байж болно.

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ багасч байгаа нь дэлхийн нийтлэг үзэгдэл болсон ба эрүүл мэндийн онцлох эрсдлүүд, эрүүл мэндийн гол асуудлууд ихэсч байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хязгаарлагдмал хүртээмжтэй байгаагийн шалтгаан нь нийгэм доройтож, дэд бүтцийн хүртээмж муу, биеийн өвчинг дутуу оношлох, хяналтгүй эмчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээг дутуу зохион байгуулах зэрэг байж болно.

Илаарших

Илаарших гэдэг нь анх удаа сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай болсон хүнээс гаралтай ойлголт юм. Илаарших гэдэг ойлголт нь хувь хүн бүрт өөр өөр байдаг учир нэгдсэн нэг тодорхойлолт байхгүй. “Илаарших” гэдэг нь “анагаах” гэж эрүүл мэндийн мэргэжилтнүүд боддог хэдий ч илаарших гэдэг ойлголт бол бүх төрлийн үйлдэлд хамаардаг, дээрх ойлголтоос ч илүү өргөн утгатай. Илаарших гэдэг нь хувь хүний өсч хөгжиж, зовлон шаналалаас шилжих явц юм – энэ нь бүрэн дүүрэн, сэтгэл хангалуун амьдрах хүний хүч чадал, чадварыг онцолдог эрх мэдэлжүүлэх явц юм. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийн хувьд илаарших гэдгийг таатай амьдрах, мөрөөдөл, зорилгоо дагах, урамшуулах харилцаа үүсгэх, өвчний шинж тэмдэг, хүндрэлээс гадна сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаа даван туулах, өвчний дахин үгдрэлтийг бууруулах, эмнэлгээс гадуур байх, ажил хийх зэргээр тайлбарлаж болно.

Жишээ 4

Илаарших талаарх хувь хүний бодол

Миний хувьд илаарших гэж дэлхий дээр бусадтай тайван амгалан, аз жаргалтай байж, ирээдүйд итгэл дүүрэн амьдрах гэсэн утгатай. Бүх сөрөг туршлагаасаа сурч сайн хүн болно гэсэн үг. Өөрөөр хэлбэл би хэн байх, юу мэдрэхээсээ айдаггүй гэсэн үг. Амьдралдаа эерэг эрсдлийн талаар ярина гэсэн үг. Одоо үед айх аюулгүй амьдарна гэсэн үг. Би хэн гэдгээ мэдэх болон оршин тогтнох чадвартай гэсэн үг.

Сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой зарим нэг онцгой асуудлууд

Хүүхдүүд ба өсвөр үе

Насанд хүрсэн хүмүүсийн нэгэн адил хүүхдүүд болон өсвөр үеийнхэн ч сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай тулгардаг. Тэдний асуудлыг хайхрахгүй орхиж, эсвэл тэднийг оюуны хомсдолтой гэж буруу оношилдог. Дэлхийн хүүхэд, өсвөр үеийн 20% нь сэтгэцийн эрүүл мэндийн болон ижил төрлийн асуудалтай байдаг гэсэн тооцоо байдаг. Хүүхэд болон өсвөр үеийнхэнд анхаарлаа бага хандуулбал сэтгэцийн эрүүл мэндэд амьдралын туршид үр дагавар гарч болно.

Хүүхэд, өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийн нөхцөл байдалд гэр бүл, нийгэм, соёлын орчин нөлөөлдөг. Ядуурал, хүчирхийлэл, биеийн болон бэлгийн хүчирхийлэл, хайхрамжгүй хандах, урамшуулахгүй байх нь ямар нэгэн байдлаар нөлөөгөө үзүүлдэг. Ээжийн сэтгэцийн эрүүл мэнд хүүхдийн сэтгэхүй, нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжилтэй холбоотой байдаг гэсэн нотолгоо байдаг. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай эцэг, эхээ асардаг хүүхдүүд хэрэгтэй анхаарал халамжаа авч чаддаггүй учраас тэд их эмзэг байдаг. Тэд эцэг эхээ хариуцах хариуцлагын түвшин тэдний чадлаас хэтэрсэн байдаг.

Хүүхэд, өсвөр насны хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд анхаарал тавих нь чухал боловч тэднийг хэтрүүлэн оношилж, сэтгэцийн гэдэг нэр шошго зүүх нь тэднийг энгийн амьдрах, хөгжихөд нь сөрөг нөлөө үзүүлж, хүүхэд, гэр бүлд аль алинд нь сөрөг үр дагавар бий болгох магадлалтай.

Хүйс

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын тархац эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дунд ижил байгаа хэдий ч ямар нэгэн онцгойлсон нөхцөл байдалд хүйсийн ялгаа гарч байна. Тухайлбал эмэгтэйчүүд айдас, гутралд илүү ордог бол эрэгтэйчүүд архинаас хамааралтай болж, амиа хорлох оролдлого илүүтэй хийдэг.

Сэтгэцийн эрүүл мэндийн нийтлэг асуудлуудад хүйсийн хувьд гардаг эрсдлийн хүчин зүйлүүд байдаг бөгөөд эмэгтэйчүүд пропорционал бусаар өртдөг. Ихэнх нийгэмд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү доогуур үнэлэгддэг нь тэд ноомой, хүлцэнгүй байж, илүү доод байр суурьтай болж, өөрийгөө доогуур үнэлдэг, арчаагүй, аливаа зүйлийг даван туулах чадваргүй болох зэрэгт хүргэдэг. Эмэгтэйчүүд эрэгтэй хүмүүстэй харьцуулахад хүч чадалгүй, нөөц бололцоонд хүрэх хүртээмж бага, өөрийнхөө амьдралыг хянах хяналт бага байдаг.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүйсэд суурилсан биеийн болон бэлгийн хүчирхийлэл нь доромжлол, басамжлал, хараат байдалд оруулж, урхинд орсон мэт сэтгэгдэл төрүүлдэг. Бэлгийн хүчирхийлэл нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай эмэгтэйчүүдэд маш нийтлэг тохиолддог. Мөн эмэгтэйчүүд эрүүл мэндийн үйлчилгээ авахдаа эрэгтэйчүүдээс илүү ялгаварлан гадуурхалтад өртдөг.

Гамшгийн нөхцөл байдал

Дайн болон бусад гамшгууд нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хамт илэрч байдаг учраас гамшгийн нөхцөл байдлын үед сэтгэцийн өвчнөөс илааршсан

хүмүүсийн хэрэгцээг анхаарч үзэх ёстой. Одоо байгаа нөөц бололцоо нь ихэнхдээ хангалтгүй, хүнд осол гэмтлийг даван туулахад хэрэгтэй цаг хугацааг дутуу тооцоолсон байдаг. Осол гэмтэлд орсон сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст сэтгэл хөдлөлийн дэмжлэг, боловсрол, даван туулах эерэг аргуудыг санал болгох зэрэг дэмжлэг хэрэгтэй байж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс зэрэг зарим бүлэг хүмүүс гамшгийн нөхцөл байдлаас үүссэн нийгэм, сэтгэл зүйн асуудалд өртөх эрсдэл нь илүү өндөр байдаг. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс өөрийн онцгой нөхцөл байдал болох тусгаар байх, буруу ойлголт, айдас, түгшүүр, өөрөө өөрийгөө хорих, хөгжлийн бэрхшээл эсвэл ядуу зүдүүгээсээ болоод гамшгийн нөхцөл байдлын үеийн дэмжлэг туслалцаа үзүүлэх үед хүртэж чадаагүй байж болно. Тэдний өмнө нь тогтвортой барьж байсан нийгмийн дэмжлэг нь гамшгаас болоод алдагдсан, эсвэл гэр бүл нь тэднийг асран хамгаалах нэмэлт ачааллаас үүдээд түүнийг орхих эрсдэл илүү болж болох юм. ХОТСЗ хөтөлбөр гамшгийн нөхцөл байдлын үед сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст анхаарлаа хандуулах нь чухал. Учир нь тэдэнд онцгой анхаарал хандуулахгүй бол тэд мартагдах эсвэл үл хайхрагдах магадлалтай (ХОТСЗ ба Хүн төрөлхтөний гамшиг хэсгийг уншина уу).

Санал болгож буй үйл ажиллагаанууд

Сэтгэцийн эрүүл мэндийг дэмж

Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжихэд соёл, нийгэм эдийн засаг болон сэтгэцийн эрүүл мэндийн бодлогыг тодорхойлогч хүчин зүйлсүүд, тухайлбал ядуурал, хүчирхийлэл, хайхрамжгүй байдал, бэлгийн хүчирхийлэл зэргийг бусад холбогдох салбаруудтай нь хамт анхаарч үздэг. ХОТСЗ хөтөлбөр тухайн орон нутагт сэтгэцийн эрүүл мэндийг дараах байдлаар дэмжинэ. Үүнд:

- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс болон бүх хүмүүсийн үндсэн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хамруулсан орчинг бий болго.
- Архи, эмэнд донтох, хүйсийн ялгаварлал, хамт олон болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хамтын хариуцлагыг дэмжиж, хамт олны сүлжээг бэхжүүл.
- Сэтгэцийн эрүүл мэнд болон сайн сайхан байхыг дэмжихийн тулд бусад бүх гол хүмүүстэй түншил. Тухайлбал хүйсийн асуудлаар эмэгтэйчүүдийн клубтэй ажиллах эсвэл хүүхдэд эрт дэмжлэг туслалцаа үзүүлэхэд орон нутгийн засгийн газрын бус байгууллагатай ажиллах гэх мэт.
- Хүүхдийн хөгжлийг сайжруулахын тулд хүүхдүүд болон эцэг эхтэй эерэг харьцаа үүсгэхийг дэмж.
- Бодисонд донтох болон хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд туслахын тулд оюутнуудын нийгмийн болон сэтгэл хөдлөлийн чадавхийг сайжруулах нотолгоонд суурилсан хөтөлбөрийг сургуулиуд дээр хэрэгжүүлэхийг дэмж.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийн талаарх сөрөг дүр зургийг өөрчлөхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажилла. (Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг: Эрүүл мэндийг дэмжих хэсгийг уншина уу)

Жишээ 5 Ямайка

Эерэг харьцааг дэмжих

Ямайкийн нийгмийн эмзэг бүлгийн эхчүүдийн нярай хүүхдэд эрт дэмжлэг үзүүлэх зорилгоор гэрээр тогтмол очих хөтөлбөр нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай өсвөр үеийнхнийг өөртөө итгэлтэй болгож, сургууль завсардалтыг багасгаж, нийгмийн эсрэг зан үйлийг багасгаж удаан хугацаанд үр ашгийн нөлөөг харуулж чадсан.

ХОТСЗ хөтөлбөрт хамруулахыг дэмж

ХОТСЗ хөтөлбөрт сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг хамруулахад дараах үйл ажиллагаануудыг санал болгож байна.

- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг хамруулах болон дэмжлэг үзүүлэх эерэг хандлагатай болохын тулд ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын талаар тохирох сургалтанд хамрагдах.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдийг ХОТСЗ хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах үйл явцад хамруулж, тэдэнтэй зөвлөлдөх.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдтэй хамтарч тэднийг үндсэн хэрэгцээг (эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол, амьжиргаа болон нийгмийн аюулгүй байдал) хангах боломжит шийдвэр болон саад бэрхшээлийг олж илрүүлэх.
- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудад зориулсан сургалтанд хичээл заах туршлагатай сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээг хүртдэг хэрэглэгчид эсвэл тэдний гэр бүлийн гишүүдийг олж илрүүлэх.

Хамт олны дунд үүссэн буруу ойлголт болон ялгаварлан гадуурхалтыг даван туул

Олон нийт сэтгэцийн эрүүл мэндийн асуудал болон илаарших боломжийн талаарх мэдлэг маш хязгаарлагдмал байдаг. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг нийгэмд идэвхтэй оролцуулахын тулд нийтлэг цуу яриа, мухар сүжиг, ялгаварлан гадуурхалтын талаар анхаарах ёстой. ХОТСЗ хөтөлбөр эдгээр зүйлийг хийхэд гол үүрэг гүйцэтгэнэ. Дараах үйл ажиллагаануудыг хийхийг санал болгож байна.

- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд бүх хүмүүстэй цаг ямагт нэр хүндийг нь хүндлэх ёстой.
- Олон нийтэд сэтгэцийн эрүүл мэндийн талаар эерэг мэдээлэл олгож чадах орон нутгийн гол хүмүүсийг олж илрүүлэх. Тэд нөлөө үзүүлэхүйц хүмүүс байдаг, тухайлбал орон нутгийн улс төрийн болон шашны манлайлагч нар байж болно.
- Тэдгээр хүмүүстэй холбоо тогтоож, тэдэнд сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын талаар мэдээлэл олгох хэрэгтэй. Тухайлбал тэднийг ХОТСЗ хөтөлбөрөөс зохион байгуулж буй үйл ажиллагаанд урьж оролцуулж болно.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын талаар ард түмэнд хэрхэн мэдээлэл олгох арга замын талаар ярилц. Тухайлбал шашны тэргүүлэгчид өөрсдийнхөө сүсэгтэн олонд энэхүү мэдээллийг өгч болно.

- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүстэй холбоотой ажиллахыг хүсч буй хүмүүс, бүлгийг илрүүлж, сөрөг таамаглал, хандлагыг байхгүй болгохын төлөө ажиллах хэрэгтэй. Тухайлбал тэдгээр хүмүүс нь цагдаа, эрүүл мэндийн ажилтнууд, нутгийн анагаах увидастан (бариач, илээч) зэрэг байж болно.
- Орон нутгийн хүмүүст сургалт зохион байгуулж, боловсрол олгох хэрэгтэй. Сэтгэцийн эрүүл мэндийн талаарх цуу яриаг (тухайлбал сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс хэрцгий байдаг) арилгахын тулд үнэн зөв мэдээлэлээр хангах. Мөн сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаас ангижрахад анагаахын болон сэтгэл зүйн эрчимтэй, үр дүнтэй эмчилгээ байдаг гэдгийг хүмүүст ойлгуулах.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдийг ялгаварлах зан үйл ажиглагдвал хүний эрхийг нь дэмж. Сайн үлгэр жишээ болж, эерэг зан үйлийг бусдад харуул.

Жишээ 6

Сэтгэцийн эрүүл мэндийн ойлголтыг хувь хүнтэй нь харьцаж өөрчлөх нь

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс, бусад хүмүүс хоорондоо шууд харьцах нь сөрөг хандлагыг өөрчлөх хамгийн үр дүнтэй арга байдаг. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг хамт олны эсвэл оюутнуудын уулзалтанд урь. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаасаа ангижирч чадсан, гэр бүл, ажил төрөл, хамт олны гишүүний үүргээ биелүүлж яваа тэдгээр хүмүүс ялгаварлан гадуурхахын эсрэг маш хүчтэй нөлөө үзүүлж чадна.

Илааршах явцад дэмжлэг үзүүл

Илааршилт нь хүний хүч чадал, тэдний амьдралаас таашаал авах, үр өгөөжтэй байх чадавхад анхаарлаа хандуулдаг. Илааршах явц нь иж бүрэн явц бөгөөд анагаах, сэтгэл зүй, нийгэм эдийн засгийн оролцоо чухал үүрэг гүйцэтгэдэг.

Эмнэлгийн тусламж авахыг нь чиглүүлж өг

Буурай хөгжилтэй оронд амьдарч байгаа сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс ядуу тарчиг, алс хол, нарийн мэргэжлийн үйлчилгээ олдоц багатайн улмаас эмнэлгийн үйлчилгээ авахад хүндрэлтэй байдаг. Нарийн мэргэжлийн болон ерөнхий эрүүл мэндийн үйлчилгээг хүргэхийн тулд ХОТСЗ хөтөлбөр эрүүл мэндийн анхан шатны тусламжийн зохион байгуулалт болон орон нутгийн сэтгэцийн эрүүл мэндийн нөөц бололцоотой хамтарч ажиллах хэрэгтэй. Дараах үйл ажиллагаануудыг санал болгож байна.

- Сэтгэцийн эрүүл мэндийн нарийн мэргэшлийн үйлчилгээ (клиник, эмнэлэг, түр байх газар, хамт олны төв, засгийн газрын бус байгууллага) үзүүлэх бүтэц, байрлал, ажилтнуудыг олж илрүүл. Үүнийг хамт олон, бүс, үндэсний түвшинд хийж болно.

- Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээтэй танилцаж, сайн харилцаатай бай. Тэдний үйлчилгээ, (сэтгэц нөлөөт эмчилгээ байгаа эсэх), бодлого, зуучлах механизм, нээх цаг, зардлын талаар мэдээлэл солилц. ХОТСЗ хөтөлбөрийн талаар болон ХОТСЗ хөтөлбөр тэдний ажилд хэрхэн туслах талаар мэдээлэл өг.
- Орон нутгийн анагаах увидастан (бариач, илээч), шашны манлайлагч нарын жагсаалтыг гаргаж, тэдэнтэй уулзаж, туршлага солилцож, санаа бодлоо хуваалцаж, бие биедээ харилцан ойлголт өгч, бие биенээ хүндэтгэ.
- ХОТСЗ хөтөлбөр болон эрүүл мэндийн анхан шатны тусламжийн ажилтнууд шаардлагатай үед сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд зуучлах чадвартай байх ёстой – шаардлагатай бол сургалт зохион байгуул.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүд сэтгэц нөлөөт эмийн гаж нөлөөний талаар мэдлэгтэй байх ёстой бөгөөд тэд өгсөн мэдээллийг ойлгосон эсэхийг баталгаажуул.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст туслахын тулд эрүүл мэндийн тусламжийн ажилтнууд орон нутгийн анагаах увидастан (бариач, илээч) нартай хамтран ажилла.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг эрүүл мэндийн анхан шатны тусламжийн тогтолцоогоор дамжуулж, хүмүүсийн ойлголтыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн анхан шатны тусламжийн ажилтнуудад холбогдох мэдээлэл олгох замаар ерөнхий эрүүл мэндийн үйлчилгээ авахад нь тусал.
- Хамт олонд түшиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийн хөтөлбөртэй газарт хамтын ажиллагаа бий болгож, түншлэл байгуул – ХОСЗ хөтөлбөр амьжиргаа гэх мэт бусад хэрэгцээнд анхаарлаа хандуулахад хамт олонд түшиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийн хөтөлбөр эрүүл мэндийн хэрэгцээнд анхаарлаа хандуулдаг. (Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг: Эмнэлгийн тусламж хэсгийг уншина уу)

Жишээ 7 Белиз

Сэтгэцийн эрүүл мэндийн иж бүрэн хандлага

Белизд сэтгэцийн эрүүл мэндийн сувилагч нар орон нутгийн анагаагч увидастан (бариач, илээч) нартай уулзаж мэдлэг, чадвараа хуваалцсан. Орон нутгийн анагаагч увидастан (бариач, илээч) нартай харилцаа тогтоосноор сэтгэцийн эрүүл мэндийн хэрэгцээг хангах үр дүнтэй арга болохыг сувилагч нар олжээ. Уламжлалт болон энгийн хандлагын аль нь ч сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн иж бүрэн хандлага юм.

Сэтгэл зүйн дэмжлэг авахыг нь чиглүүлж өг

Буурай хөгжилтэй оронд нарийн мэргэжлийн сэтгэл зүйн дэмжлэг авах нь маш их хязгаарлагдмал байж болох боловч ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд үндсэн үйлчилгээг үзүүлж чадна. Дараах үйл ажиллагаануудыг санал болгож байна.

- ХОТСЗ хөтөлбөрийн болон эрүүл мэндийн анхан шатны тусламжийн ажилтнуудад сэтгэл зүйн тусламж үйлчилгээний үндсэн ойлголт өгөх сургалт зохион байгуулах. Уг сургалт маш мэдрэг байдлаар явагдах ёстой бөгөөд сэтгэл хөдлөлийн дэмжлэг (зөвлөгөө өгөх чадвар), дахин даат,гал мэдээлэл болон тайвшруулах аргын талаар заах хэрэгтэй.
- Нээлттэй илэн далангүй харилцаж, итгэж, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдтэй эерэг харилцаа тогтоо. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдтэй тогтмол уулзаж, тэд ямар байна, асуудлаа хэрхэн даван туулж байгаа зэргийг асууж, тэднийг сонсох хэрэгтэй.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүстэй ойр ажиллаж, тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд нь туслаж, стрессээ удирдаж, даван туулах чадвараа хөгжүүлэх зэргийг сурахад нь дэмжлэг үзүүл.
- Орон нутгийн анагаах увидастан сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд сэтгэл зүйн ямар үйлчилгээ үзүүлдгийг мэдэж, тэрхүү үйлчилгээг авах хамгийн сайн аргыг олох.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг бие биедээ харилцан туслах, эрх мэдэлжүүлэх боломжийг нь олгохын тулд өөрөө өөртөө туслах бүлэг байгуулахыг дэмжих. Хэрэв өөрөө өөртөө туслах бүлэг байгаа бол түүн дотор сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг хамруулахыг хөхиүлэн дэмж.

Нийгмийн зүгээс дэмжлэг авахыг нь чиглүүлж өг

ХОТСЗ хөтөлбөр нийгмийн зүгээс авах дэмжлэгийг дараах аргаар чиглүүлж болно.

- Өөрийн орон нутагт (хамт олон) буй холбогдох нийгмийн үйлчилгээнүүдийг ол.
- Нийгмийн хэрэгцээг мэдэж, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдтэй хамтарч боломжит шийдвэрийн талаар төлөвлөгөө гарга.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийн үндсэн хэрэгцээг (хоол хүнс, ариун цэвэр, хувцас, орон байр гэх мэт) хангаж, тэдний эрхийг хамгаалахын тулд гэр бүлтэй нь хамтарч ажилла.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг өдөр тутмын гэр бүлийн үйл ажиллагаанд хамруулах талаар гэр бүлийн гишүүдэд санал дэвшүүл.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг найз нөхөд, хамаатан садантайгаа уулзаж, нийгмийн харилцаагаа дахин сэргээхийг дэмж. Харин тэдний хамаатан садан, найз нөхдөд нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын талаар ойлголт өгөх нь чухал байж болох юм.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд оролцож болох үйл ажиллагааг олж илрүүл. Тэд бага зэрэг итгэл үнэмшилтэй болж эхэлбэл тэднийг хамт олны дотор оруулж эхлэх шаардлагатай болно. Мэдээж маш их бэрхшээл тулгарна.
- Нийгмийн зүгээс дэмжлэггүй байгаа хүмүүс, гудамжинд амьдарч байгаа хүмүүс болон нийгмийн зүгээс буруу ойлголттой тулгарч байгаа хүмүүстэй тогтмол холбоо тогтоо.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийн хэрэгцээг (хоол хүнс, сэтгэлд нийцсэн орон байр, боловсрол, ажил) хангахын тулд бусад хөгжлийн салбаруудтай түншилж ажилла.

- Зардлын хүчин зүйлээс шалтгаалж эм, эмчилгээг хүртэж чадахгүй бол түүнийг даван туулах арга замыг ол. (Нийгмийн бүрэлдэхүүн хэсгийг уншина уу)

Амьжиргааны боломжинд хүрэхэд чиглүүлж өг

Амьжиргааны үйл ажиллагаанд оролцох нь илааршихявцын чухал хэсэг нь юм. Орлого олох нь хүн бие дааж, хараат бус болж, өөртөө итгэх итгэл нь нэмэгдэж, нийгмийн сүлжээ бий болгож, нийгмийн хувьд үнэлэмжтэй байр суурьтай болох, өөрсдийнхөө амьдралыг хянах зэрэг боломжтой болно. Амьжиргааг сайжруулахын тулд дараах үйл ажиллагаануудыг санал болгож байна.

- Орлого олох ажиллагаанд анхаарлаа хандуулсан хөгжлийн байгууллагуудыг ол. Тэдгээр байгууллагуудтай холбоо тогтоож, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг хамруулах талаар тэдэнтэй ажилла.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст бусад амьжиргааны боломжуудыг ол. Тухайлбал тэднийг хуучин ажилд нь буцааж оруулахад нь туслах, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг ажилд авах талаар орон нутгийн бизнестэй холбоо тогтоох зэрэг байж болно.
- Хүмүүс хуучин ажилдаа эргэж орохоор болбол ажлын орчныг тохируулах (хэрэв анхаарлаа төвлөрүүлэх, шуугиан нь түүний хувьд мэдрэг асуудал бол тайван орчинд ажиллах, ажлын цаг уян хатан байх, аажмаар ажиллах цагийг ихэсгэх) талаар ажил олгогчтой нь хамтарч ажилла.
- Тухайн орны холбогдох хууль тогтоомжийн дагуу ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнө хүлээсэн үүрэгтэйг нь мэдээл. (Амьжиргаа бүрэлдэхүүн хэсгийг уншина уу)

Жишээ 8 Танзани

Утга учиртай амьдралын зүгт

Танзанийн Мтвара сэтгэцийн эрүүл мэндийн хөтөлбөр сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст хүртээмжтэй, боломжийн, нийцсэн эмчилгээний сонголтыг бий болгохын тулд таван дүүргийн эрүүл мэндийн газартай хамтран ажилласан. Энэхүү туршилтын төслийн эхний үед 1026 хүн эмчилгээнд хамрагдаж, улмаар 4711 хүн болтлоо өргөжин тэлсэн. Эмчилгээ, сэтгэл зүйн дэмжлэг нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай олон хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулж чадсан. Тэдний амьдрал илүү тогтвортой болж, олон хүмүүс ажилдаа буцаж орж, зарим нь шинэ ажилд ч орсон. “Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийн зарим шинж тэмдэг арилж, үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, нийгмийн хандлага мөн өөрчлөгдөж байна” гэж Хөтөлбөрийн менежер дурджээ.

Гэр бүлийн гишүүдэд тусал

Хөгжил буурай орнуудад гэр бүл сэтгэцийн эрүүл мэндийн хамгийн чухал эх үүсвэр болдог. Дараах үйл ажиллагаанууд санал болгож байна. Үүнд:

- Гэр бүлийн гишүүдэд сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, түүнийг даван туулах стратегийн талаар мэдээлэл өг. Мэдээлэл өгөхөөсөө өмнө сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүнээс зөвшөөрөл авахаа мартуузай.

- Гэр бүлийнхэнд нь олон хэрэгцээ шаардлагатай хүмүүсийг асрахад нь тусал. Тэдэнд урам зориг өг. Гэр бүлийн бусад гишүүд болон хамт олон хамтарч асрах талаар ярилц.
- Гэр бүлийн гишүүдийг өөрөө өөртөө туслах бүлэгт орж, бусадтай туршлагаа хуваалцахыг санал болго.

Жишээ 9 Уганда

Ээж нар туршлагаа хуваалцаж байна

Угандагийн хэсэг бүлэг ээж нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн байгууллагад хамрагддаг юм. Тэд орон нутгийн төрөх эмнэлэг дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрүүлсэн ээж нартай уулзахаар очдог. Тэд ээж нартай уулзаж, уй гашууг нь хуваалцаж, өөр эерэг туршлагыг хуваалцаж, ирээдүйд нь найдвар төрүүлдэг.

Эрх мэдэлжүүлэх явцад хувь нэмрээ оруул

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаас ангижрах нь эрх мэдэлжүүлэх явцтай маш холбоотой байдаг. Энэхүү Удирдамжийн “Эрх мэдэлжүүлэх” бүрэлдэхүүн хэсэгт илүү нарийвчилсан үйл ажиллагаануудыг дурдсан учраас энд цөөн үйл ажиллагаануудыг жагсаав. Үүнд:

- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүстэй болон тэдний гэр бүлийн гишүүдтэй харилцахдаа тэднийг хүндэтгэж харьцах хэрэгтэй.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүд өөрсдийн гэсэн мэдлэг, чадвартай гэдгийг санаж байх хэрэгтэй. Хүмүүсийн чаддаг зүйл дээр анхаарлаа тавьж, тэднийг илааршуулахад өөрсдийг нь идэвхтэй оролцуулах хэрэгтэй.
- Хүмүүст (тохиромжтой бол тэдний гэр бүлийн гишүүдэд) өөрт нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын талаар ямар нэгэн нэр шошго зүйлгүйгээр мэдээлэл өг. Тэд хүний эрхийн талаар мэдэж байгаа эсэхийг баталгаажуулж мөн эрхээ хэрхэн эдлэх талаар ойлголт өгөх хэрэгтэй.
- Хүмүүст хийж байгаа эмчилгээний талаар мэдээлэл олгож, мэдээлэл дээрээ үндэслэж шийдвэр гаргахад нь хамт олонд тусал.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдийг өөрөө өөртөө туслах бүлэгтэй холбож өг.
- Өөрөө өөртөө туслах бүлгийн гишүүдэд хамт олонд түшиглэсэн, амьдарч байгаа газарт ойр сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээг хөгжүүлэх талаар мэдээлэл олгож, дэмж.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг эрхээ эдлэхэд нь туслахын тулд орон нутгийн, үндэсний хууль дүрмүүд болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн талаар ойлголтыг нэмэгдүүл.

(Илүү дэлгэрэнгүй мэдээллийг ХОТСЗ хандлагын Удирдамжийн “Эрх мэдэлжүүлэх” бүрэлдэхүүн хэсгийг уншина уу)

Ашигласан материалууд

- Promoting mental health. Concepts, emerging evidence, practice. Summary report. Geneva, World Health Organization, 2004 (www.who.int/mental_health/evidence/en/promoting_mhh.pdf, accessed 30 April 2010).
- Convention on the Rights of Persons with Disabilities. United Nations, 2006 (www.un.org/disabilities/, accessed 30 March 2010).
- Chatterjee S et al. Evaluation of a community-based rehabilitation model for chronic schizophrenia in rural India. British Journal of Psychiatry, 2003, 182:57–62.
- Patel V et al. Global mental health 3: treatment and prevention of mental disorders in low-income and middle-income countries. The Lancet, 2007, 370:991–1005.
- mhGAP: Mental health gap action programme: scaling up care for mental, neurological and substance use disorders. Geneva, World Health Organization, 2008 (www.who.int/mental_health/mhgap_final_english.pdf, accessed 30 April 2010).
- World health report 2001 – mental health: new understanding, new hope. Geneva, World Health Organization, 2001 (www.who.int/whr/2001/en/, accessed 30 April 2010).
- Thornicroft G. Shunned: discrimination against people with mental illness. New York, Oxford University Press, 2006.
- Elbogen EB, Johnson SC. The intricate link between violence and mental disorder: results from the national epidemiologic survey on alcohol and related conditions. Archives of General Psychiatry, 2009, 66(2):152–161.
- Watson AC et al. Self-stigma in people with mental illness. Schizophrenia Bulletin, 2007 (http://
- schizophreniabulletin.oxfordjournals.org/cgi/content/abstract/sbl076v1, accessed 30 April 2010).
- Mental health, human rights and legislation: WHO's framework. Geneva, World Health Organization (undated) (www.who.int/mental_health/policy/fact_sheet_mnh_hr_leg_2105.pdf, accessed 30 April 2010).
- 10 facts on mental health. Geneva, World Health Organization (undated) (www.who.int/features/factfiles/mental_health/mental_health_facts/en/index.html, accessed 30 April 2010).
- WHO resource book on mental health: human rights and legislation. Geneva, World Health Organization, 2005 (www.who.int/mental_health/policy/resource_book_MHLeg.pdf, accessed 30 April 2010).
- Senior K. Greater needs, limited access. Bulletin of the World Health Organization, 2009, 87:252–253.
- Robson D, Gray R. Serious mental illness and physical health problems: a discussion paper. International Journal of Nursing Studies, 2007, 44:457–466.
- Bonney S, Stickley T. Recovery and mental health: a review of the British literature. Journal of Psychiatric and Mental Health Nursing, 1008, 15:140–153.
- Schiff AC. Recovery and mental illness: analysis and personal reflections. Psychiatric Rehabilitation Journal, 2004, 27(3):212–218.

- Caring for children and adolescents with mental disorders. Setting WHO directions. Geneva, World Health Organization, 2003 (www.who.int/mental_health/media/en/785.pdf, accessed 30 April 2010).
- Prince M et al. Global mental health 1: No health without mental health. The Lancet, 2007, 370:859–877.
- Gender and women's mental health. Geneva, World Health Organization, (undated) www.who.int/mental_health/prevention/genderwomen/en/, accessed 30 April 2010).
- Inter-Agency Standing Committee (IASC). IASC guidelines on mental health and psychosocial supportin emergency settings. Geneva, 2007 (www.who.int/mental_health/emergencies/guidelines_iasc_mental_health_psychosocial_june_2007.pdf, accessed 30 April 2010).

Уншихыг зөвлөж буй материалууд

- Basic Needs. Mental health and development. E-journal (www.mentalhealthanddevelopment.org/, accessed 30 April 2010).
- Cohen A, Kleinman A, Saraceno B, eds. World mental health casebook. Social and mental health programs in low-income countries . New York, Kluwer Academic/Plenum Publishers, 2002.
- Community mental health policy (update of mental health policy from 2001). CBM, 2008 (www.cbm.org/en/general/downloads/19914/CBM_Community_Mental_Health_Policy.pdf, accessed 30 April 2010).
- Fisher D, Chamberlin J. Consumer-directed transformation to a recovery based mental health system, 2004 (www.power2u.org/downloads/SAMHSA.pdf, accessed 30 April 2010).
- Global Forum for Community Mental Health. Mission statement, experiences, contacts, resources, undated (www.gfcmh.com/, accessed 30 April 2010).
- Leff J, Warner R. Social inclusion of people with mental illness . Cambridge, Cambridge University Press, 2006.
- Patel V. Where there is no psychiatrist. A mental health care manual . London, Gaskell, 2003.
- Stastny P, Lehmann P, eds. Alternatives beyond psychiatry. Berlin, Peter Lehmann Publishing, 2007.
- World Association for Psychosocial Rehabilitation. WAPR Bulletin (www.wapr.info/wapr_bulletins.htm, accessed 30 April 2010).
- World Network of Users and Survivors of Psychiatry. Human rights position paper of WNUSP, 2001 (www.wnusp.net/wnusp%20evas/Dokumenter/Human%20Rights%20Position%20Paper.html, accessed 30 April 2010).

Хамт олонд түшиглэсэн сэргээн засалт ба ХДХВ/ДОХ

Танилцуулга

Хүний дархлал хомсдолын вирус/дархлалын олдмол хомсдол (ХДХВ/ДОХ) нь цагаач ажилчид, секс ажилчид, эрэгтэй хүнтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд, судсаар эм хэрэглэгчид, уугуул иргэд гэх мэтийн өндөр эрсдэлд байгаа хүмүүс ихэнхдээ өртдөг боловч дэлхийн хамгийн эмзэг хүн амын нэг болох бие бялдар, сэтгэц, оюун санааны эсвэл мэдрэхүйн байнгын согогтой хүмүүсийг бүрэн мартсан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ХДХВ-ийн халдвар авах эрсдэлгүй, учир нь тэд бэлгийн харьцаанд идэвхтэй ордоггүй, эм хэрэглэдэггүй, хүчиндүүлэх, хүчирхийлэлд өртөх эрсдэл бага гэж ихэнхдээ үздэг.

НҮБ-ын ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр (UNAIDS), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), Хүний эрхийн дээд комиссар (OHCHR) нарын байгууллагуудын саяхан хийсэн Хөгжлийн бэрхшээл ба ХДХВ-ийн талаарх хамтарсан мэдэгдэлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ХДХВ-т өртөх өндөр эрсдэлтэй хүн амын нэг гэж зарласан хэдий ч засгийн газрууд, бодлого боловсруулагч нар ХДХВ/ДОХ-ын асуудалд хөгжлийн бэрхшээлийг оруулж, төлөвлөх нь тун ховор байна. Олон асуудал, саад бэрхшээлүүдээс болоод ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх, эмчлэх, асрах, туслах дэмжих хөтөлбөрүүд болон үйлчилгээ байхгүй, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжгүй байсаар байна.

Энэ хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ХДХВ/ДОХ-д өртөж, хөтөлбөр үйлчилгээнүүд тэдэнд хүртээмжгүй байгаа талаар голчлон анхаарч байгаа хэдий ч эсрэгээрээ ХДХВ/ДОХ-оор өвчилсөн болон эмчилгээ хийлгэж байгаа хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй болж болох юм. ХДХВ-тэй хүмүүс хүрээлэн буй орчинтойгоо харилцаж, нийгэмд бусдын нэгэн адил бүрэн дүүрэн оролцоход нь саад болж, түүнд ямар нэгэн согог (импэйрмент) үүсч, хөгжлийн бэрхшээлтэй гэж тооцогдож болох юм.

Ихэнх ХОТСЗ хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлийг ХДХВ/ДОХ-той холбож үзээгүй байдаг. Гэхдээ ХОТСЗ нь хамт олонд түшиглэн хамруулах стратеги учир ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр, үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлийг оруулахад үр дүнтэй ажиллаж болно. ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд хандсан, тэрхүү хэрэгцээнд хариу үзүүлэх, мөн ХДХВ/ДОХ-той бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмшүүлэх, тэгш боломж олгоход дэмжиж тусалдаг байх ёстой.

Жишээ 10 Намиб

Алексиа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хуулиудад түлхэц өгөв

Африкийн ихэнх оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ХДХВ-ийн халдвар авах эрсдэл хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсээс илүү байна гэж Намибийн анхны парламентын хөгжийн бэрхшээлтэй гишүүн Алексиа Маномбе-Нкубе хэлжээ.

Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмээс тусгаарласны гай гэж мэдэгдэв. Тухайлбал харааны бэрхшээлтэй хүмүүс эрүүл мэндийн мэдээлэл бүхий танилцуулга, сурталчилгаа, зурагт хуудсыг уншиж чадахгүй. Сонсголын бэрхшээлтэй хүмүүс халдвараас хэрхэн хамгаалах, урьдчилан сэргийлэх талаарх телевиз, радиогийн нэвтрүүлгийг сонсож чадахгүй өнгөрдөг. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс эрүүл мэндийн төв очиж зөвлөгөө авах эсвэл сорил тавиулж чаддаггүй. Эрүүл мэндийн боловсрол олгох материалууд Брайл форматаар юмуу эсвэл дохионы хэлээр маш ховор байдаг. Заримдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шууд бай болгодог. Оюуны хомдсолтой охид, эмэгтэйчүүд аюултай бэлгийн харьцаанд орох нь амархан байдаг.

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч хэдэн байгууллага өөрсдийнхөө хөтөлбөрт энэ асуудлыг тусгасан байдаг вэ? Хатагтай Алексиа Маномбе-Нкубе Намибийн парламентад хөгжлийн бэрхшээлийн талаарх шинэ хууль гаргахад өөрийн байр суурийг илэрхийлж түлхэц өгөв. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, эмчлэхийг аль алийг нь хийхгүйгээр Мянганы хөгжлийн зорилтын 6 буюу ХДХВ/ДОХ ба бусад өвчинтэй тэмцэх гэсэн зорилгыг биелүүлэх боломжгүй юм.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, эмчлэх, асрах, дэмжих хөтөлбөр болон үйлчилгээнүүдийг хүртэхэд оршино.

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг

ХОТСЗ хөтөлбөрийн үүрэг нь (i) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр болон үйлчилгээний талаар мэддэг байх; (ii) ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр болон үйлчилгээнүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд хүртээмжтэй байх; (iii) хөтөлбөртөө байнгын эсвэл түр зуурын хөгжлийн бэрхшээлтэй байгаа ХДХВ/ДОХ-той хүмүүсийг хамруулах явдал юм.

Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр болон үйлчилгээг хүртдэг болно.
- ХДХВ/ДОХ-той хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ХОТСЗ хөтөлбөрүүдэд хамрагддаг болно.
- Холбогдох гол хүмүүс хөгжлийн бэрхшээл болон ХДХВ/ДОХ-ын талаар мэдлэгтэй болно.
- Хөгжлийн бэрхшээл, ХДХВ/ДОХ-ын гол хүмүүс сүлжээ байгуулж, түншлэн ажиллана.
- Хөгжлийн гол гол салбарууд ХДХВ/ДОХ-той хүмүүсийг хамруулна.
- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд ХДХВ эерэг байхаас сэргийлсэн мөн ХДХВ/ДОХ-той байвал тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлдэг ажлын байрны бодлого баримталдаг болно.
- Үндэсний ХДХВ/ДОХ-ын бодлого, төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулна.

Гол ойлголтууд

ХДХВ/ДОХ

ХДХВ нь ДОХ-ыг үүсгэдэг вирус юм. Шууд цусаар болон хүний аль нэг шингэнээр дамжин халдварладаг. Тухайлбал хамгаалалтгүй бэлгийн харилцаанд орох, халдвартай хүнтэй нэг зүү ашиглах зэрэгт ХДХВ-ийн халдвар авч болно. Хэрэв эх нь халдвартай байсан бол нярай хүүхэд төрөхөөс өмнө, төрөх явцад эсвэл төрсний дараа халдвар авч болно.

ДОХ нь ХДХВ-ийн халдварын эцсийн шат юм. ДОХ нь хүний биеийн дархлааны тогтолцоонд нөлөөлж, хүний өвчинтэй тэмцэх чадлыг нь бууруулдаг. ДОХ нь хүний амьдралд хор нөлөө үзүүлж, зарим тохиолдолд хавдар, мөн мэдрэлийн тогтолцооны үйл ажиллагааг удаашируулдаг. ХДХВ-ийн эерэг үзүүлэлттэй хүн бүр ДОХ-оор өвчилдөггүй – ХДХВ-тэй хүн олон жилийн өмнө ДОХ-той болчихсон ч байж болно.
Ретро вирусийн эсрэг эмчилгээ нь ХДХВ-ийн вирусийн идэвхжилийг удаашруулдаг боловч ХДХВ/ДОХ-ыг анагааж чадахгүй. Одоогийн нөхцөлд урьдчилан сэргийлэх нь хамгийн сайн арга болж байна.

ХДХВ/ДОХ-той хүмүүс ба хөгжлийн бэрхшээл

ХДХВ/ДОХ-той олон хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй байдаг. Ретро вирусийн эсрэг эмчилгээ нь олон хүнийг илүү удаан амьдруулж байгаа боловч өвдөх, сайжрах циклийн хооронд архаг нөхцөл байдалд амьдарч байна. ХДХВ/ДОХ-той хүмүүс ХДХВ-ийн идэвхжилээс эсвэл эмчилгээнээс үүдээд байнгын эсвэл түр зуурын импейрмэнт хэлбэрт буюу эмгэг согогийн (бие махбодийн, сэтгэцийн эсвэл мэдрэхүйн) байдалд ордог. Тухайлбал, ядрах, сульдах, хоол боловсруулах асуудал, арьсны асуудал, мөн мэдрэлийн эмгэг зэрэг нь эмчилгээний гаж нөлөө болдог бөгөөд энэ нь үйлдлийн (алхах, усанд орох, машин барих) бэрхшээлд оруулж, ХДХВ/ДОХ-той хүмүүсийг хөгжлийн бэрхшээлтэй болгодог.

ХДХВ/ДОХ-той хүмүүсийн ихэнх нь ялгаварлан гадуурхалтанд өртөж, мөн тэднийг буруу ойлгодог. ХДХВ/ДОХ нь хүмүүсийн зан үйлтэй холбоотой байдаг учир нийгэмд тэднийг хүлээн зөвшөөрдөггүй, өргөн хэмжээгээр буруу ойлголттой байдаг. ХДХВ/ДОХ-той хүмүүс ихэнхдээ ялгаварлан гадуурхалтын бай болж, тэдний хүний эрх зөрчигддөг. Ихэнх нь ажлаасаа халагдаж, гэрээсээ хөөгдөж, гэр бүл, хамт олон нь тэднээс салж, тэр ч байтугай заримыг нь егүүтгэдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ба ХДХВ/ДОХ

Бэлгийн амьдрал

Бэлгийн амьдрал гэдэг нь хүмүүс бэлгийн харилцаагаар туршлага сууж, өөрийгөө илэрхийлэх арга юм. Ялангуяа ХДХВ/ДОХ-ын хувьд бэлгийн амьдрал нь маш чухал сэдэв болдог. Олон газарт соёлын онцлогоос шалтгаалж бэлгийн амьдралын талаар чөлөөтэй ярилцахад саад бэрхшээлтэй байдаг. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй холбож ярих үед олон хүмүүс таагүй байдаг боловч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд энэ нь бодит зүйл тул ярихгүй, тоохгүй өнгөрч болохгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэнэн хонгор, хүүхэд шиг бэлгийн дуршилгүй гэж боддог, мөн дотнын харилцаа үүсгэж чадахгүй, эсвэл бэлгийн хэрэгцээ бага хүмүүс гэх мэтээр ойлгодог. Харин ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бэрхшээлгүй хүмүүсийн нэгэн адил бэлгийн идэвхтэй хүмүүс байдаг. Тйимээс тэд ч бас ХДХВ-ийн халдвар авах эрсдэлтэй гэсэн үг.

Эрсдэлийн хүчин зүйлүүд

ХДХВ/ДОХ-ын мэдэгдэж буй эрсдлийн бараг бүх хүчин зүйлүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст илэрч байна гэж ХДХВ/ДОХ болон Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн судалгаанаас харагдаж байна. Эрсдлийн хүчин зүйлүүдээс дурдвал:
Бичиг үсэггүй байдал – ХДХВ-ийн талаарх мэдээллийг уншиж ойлгож, ХДХВ-ийн эрсдэлт зан үйлээ өөрчлөхөд бичиг үсэг чухал шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүн амтай харьцуулахад боловсролын түвшин бага байгааг “Боловсрол” бүрэлдэхүүн хэсэг товхимолд дурдсан байгаа бөгөөд энэ байдал нь тэднийг ХДХВ-ийн өндөр эрсдэлд байгааг харуулж байна (Боловсрол бүрэлдэхүүн хэсгийг уншина уу).

ХДХВ-ийн талаар ойлголт, мэдлэг дутмаг – Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бэлгийн харилцааны талаар мэдлэг доогуур, мөн ХДХВ-ийн талаар мэдээлэл бага авдаг. Энэ нь ХДХВ-ийн талаар гэрт болон сургууль дээрх сургалт байхгүй, бэлгийн амьдралын талаар буруу итгэл үнэмшилтэй, ХДХВ-ийн талаарх мэдлээлэл болон илгээж буй үг (мессеж) нь хүртээмжтэй форматаар байдаггүй зэргийн үр дагавар байж болно. Тухайлбал, урьдчилан сэргийлэх кампанит ажлыг зөвхөн сонин, зарлалын самбар зэргээр явуулбал харааны бэрхшээлтэй хүмүүс мэдээлэл ав чадахгүй, хэрэв зөвхөн радиогоор явуулбал сонсголын бэрхшээлтэй хүмүүс мэдээлэл авч чадахгүй, мөн хэтэрхий нарийвчилсан, ойлгоход төвөгтэй хэлээр мэдээллийг явуулбал оюуны бэрхшээлтэй хүмүүс мэдээллээс хоцорно.

Жишээ 11 Мозамбик

Бэлгийн амьдралыг хүлээн зөвшөөрөх нь

Мозамбикт хийсэн хөгжлийн бэрхшээл болон ХДХВ-ийн талаар судалгаагаар ХДХВ, ДОХ-ын бодлого, хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ерөөсөө хамрагддаггүйн шалтгаануудын нэг нь тэднийг бэлгийн харьцаанд ордог гэж хүлээн зөвшөөрдөггүй гэж гарсан. Үүнээс харахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхах, тэднийг буруу ойлгох үзэл давамгай байна.

ХДХВ-ийн эрсдэлт зан үйл – Хамгаалалтгүй бэлгийн харьцаа, эм тарьж хэрэглэж, бэлгийн ажил зэрэг зан үйлүүд ХДХВ-ийн халдвар авах эрсдлийг ихэсгэдэг. Олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эдгээр зан үйлүүдтэй байдаг гэдэг нь судалгаагаар тогтоогдсон байдаг. Өөртөө итгэх итгэл дутуу, хүсээгүй, сонирхлыг нь татаагүй зэрэг нь эрсдэлт бэлгийн зан үйлд хүргэж болно. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй өсвөр насныхан хамрагдах, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх гэх мэт хэрэгцээнээсээ үүдээд бэлгийн дарамтанд ордог. Тиймээс тэд аюулгүй бэлгийн харьцааг зөвшилцөх чадвар нь хязгаарлагдмал байдаг.

Бэлгийн дарамт – Дэлхийн аль ч газрын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бэрхшээлгүй хүмүүсийг бодвол ихэнхдээ бэлгийн дарамтанд, хүчингийн хохирогч болдог нь ХДХВ-ийн халдвар авах өндөр эрсдэлд оруулдаг. Олон хүчин зүйлүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусламж хүсэхэд бусад хүнээс хамааралтай байх, асрамжийн газар зэрэг институтэд амьдрах, хуулийн эрхээ хүртэх хүртээмж дутмаг гэх зэрэг дарамтанд оруулж, илүү эмзэг болгодог (Нийгмийн бүрэлдэхүүн товхимолыг уншина уу).

ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, эмчлэх, асрах, дэмжихэд тулгарч буй саад бэрхшээлүүд

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сорил, зөвлөгөө, эмчилгээ, асрах, туслах зэрэг ХДХВ-ийн үйлчилгээг хязгаарлагдмал хүртдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч байгаа саад бэрхшээл нь Эрүүл мэнд бүрэлдэхүүн товхимолд дурдсантай ижил бөгөөд дараах бэрхшээлүүдийг дурдаж болно.

Бодлого – Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс амьдралын доод түвшинд амьдардаг, нийгэмд бүтээлчээр хувь нэмэр оруулж чаддаггүй гэж ихэнх хүмүүс боддог учир

бодлого баригч нарын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс юун түрүүнд цаг хугацаа, эрч хүч, нөөц бололцоогоо зориулна гэдэг нь ер бусын юм. Ретро вирусын эсрэг эмчилгээ ховор, үйлчилгээ болон тусламж дэмжлэг хязгаарлагдмал үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс асрах туслах ёстой хүмүүсийн хамгийн эцэст жагсдаг.

Орчны болон харилцааны саад бэрхшээлүүд – Клиникийн эмнэлэгт болон бусад газарт үзүүлдэг эмчилгээнүүд нь бие махбодын хувьд хүртээмжгүй (тэргэнцэртэй хүмүүс ашиглах боломжтой налуу зам байхгүй), дохионы хэлний үйлчилгээ байхгүй эсвэл Брайл, аудио эсвэл энгийн ойлгомжтой байдлаар гэх мэтээр өөр ямар нэгэн хэлбэрээр мэдээллийг түгээдэггүй байж болно.

Эрүүл мэндийн ажилтнуудын сөрөг хандлага, сөрөг мэдлэг – ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэндийн ажилтнууд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар мэдээлэл авахыг хүсэхэд элэглэж, дооглож эсвэл үл тоомсорлодог. Ихэнх оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ХДХВ/ДОХ авч чадахгүй гэж ажилтнууд буруу нотлосноор ХДХВ-ийн сорил авах төв болон ДОХ-ын клиникт оруулаагүй гэсэн мэдээ байдаг.

Эрүүлийг хайх зан үйл Health-seeking behaviour – Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ХДХВ/ДОХ-ын үйлчилгээ авч чаддаггүй нь олон шалтгаантай холбоотой: эрүүл мэндийн ажилтнуудын сөрөг хандлага нь тэднийг бэлгийн эрүүл мэндийн талаар тусламж хайж ирэхэд эсэргүүцдэг байж болно; ХДХВ/ДОХ-той холбоотой буруу ойлголтоос үүдэж ХДХВ-ийн сорил тавиулахыг хүсч ирсэн хүмүүсийг оруулахгүй, татгалзах, мөн нуущладаг; олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрүүл мэндийн үйлчилгээ авахдаа гэр бүл, найз нөхдөөсөө хамааралтай байдаг. Тиймээс эдгээр үйлчилгээг авахаасаа ичдэг, тэднийг ХДХВ/ДОХ-той гэдгийг мэдэхээс айдаг байж болно.

ХДХВ/ДОХ гэр бүлд үзүүлэх нөлөө

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүл ХДХВ/ДОХ-той байвал тэд ч бас өртдөг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр бүлээсээ өдөр тутмынхаа амьдралд үргэлж туслалцаа шаардлагатай байдаг, мөн эмнэлгийн, боловсролын эсвэл сэргээн засалтын хэрэгцээтэй байдаг учир ХДХВ/ДОХ-оос болоод гэр бүлийн орлого, нөөц бололцоо буурч, цаг хугацаа багасч, тэд орхигдож болно. ДОХ-оор ээж, аавынхаа аль нэгийг, эсвэл хоёулангий нь алдсан хүүхдүүдийн 4-5% нь хөгжлийн бэрхшээлтэй байдаг гэсэн тооцоо байдаг. Ийм нөхцөл байдалд тэд хоол тэжээлийн дутагдалд орж, орхигдож, асрамжийн газар амьдарч, эсвэр бүр хаягддаг. ХДХВ эерэг гарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ч мөн бүхий л салбарт, ялангуяа боловсролын салбарт ялгаварлан гадуурхагдаж, хаягдсан байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амд хүрэх нь

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр, үйлчилгээнд хамруулах

Хөгжлийн бэрхшээлтэй олон хүмүүсийг ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр, үйлчилгээндээ хамруулахгүй байж болно. Учир нь түүнийг хэт үнэтэй эсвэл хэтэрхий хэцүү гэж ихэнхдээ итгэдэг. Гэхдээ ХОТСЗ хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн

байгууллага, ХДХВ/ДОХ-ын сурталчилгааны ажилтнууд, сургагч багш нар, болон бодлого боловсруулагч нар тэдгээр хүмүүсийг хамруулах олон арга бий. Санал болгож буй үйл ажиллагаанууд хэсэгт практик аргуудыг бичсэн байгаа боловч дараах аргууд нь ерөнхийдөө санал болгодог. Үүнд:

- ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр, үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй болгох;
- ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр, үйлчилгээг бүгдийг хамрахаар тохируулах;
- ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр, үйлчилгээг авч чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж тусгай ажлыг бий болгож, хэрэгжүүлэх.

Дээрх арга хэмжээнүүдийг тохирох байдлаар авч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрч үйлчлэх нь чухал юм.

Сэргээн засалт

ХДХВ/ДОХ-оос үүдээд хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүс сэргээн засалт маш их шаардлагатай байдаг. Сэргээн засалт нь байдал муудахаас сэргийлж, хүмүүсийг бие даахад нь тус болдог. Сэргээн засалтыг Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг товхимолд илүү дэлгэрэнгүй тодорхойлсон байгаа учир энд нарийвчлан бичсэнгүй. Хамт олны түвшинд ХОТСЗ хөтөлбөр нь ХДХВ/ДОХ-той хүмүүст тулгардаг үйлдлийн асуудлыг шийдэхэд гол үүрэг гүйцэтгэж чадна. Мөн ХДХВ болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл, бүтээлч амьдралын хэв маягтай байхад туслах мэргэжлийн сэргээн засалт болон бусад сэргээн засалтын асуудалд тусламж дэмжлэг үзүүлж чадна.

Санал болгож буй үйл ажиллагаанууд

ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх, эмчлэх, асрах, дэмжих ажлыг чиглүүл

ХОТСЗ хөтөлбөр ХДХВ/ДОХ-той хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүрэн дүүрэн оролцоог хязгаарлаж байгаа саад бэрхшээлүүдийг дараах аргаар урьдчилан сэргийлж, эмчилж, асрах, туслах ёстой:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр, үйлчилгээний талаар мэдлэг олгож, мөн тэд оролцох эрхтэй гэдгээ мэдэх;
- ХДХВ/ДОХ-ийн хөтөлбөр, үйлчилгээ нь бие махбодын хувьд хүртээмжтэй байх. Тухайлбал ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр, үйлчилгээг хүртээмжтэй газарт шилжүүлэх, зөвлөгөө өгөх, мөн хүртээмжтэй болгоход шаардагдах тохируулгыг хийхэд ХОТСЗ хөтөлбөр тусалж болно;

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж зурагт хуудас, мэдээллийн самбар болон бусад материалуудыг тэргэнцэртэй хүн, таяг барьсан хараагүй хүн хөгжлийн бэрхшээлгүй хүмүүстэй хамт байгаа зэргээр хийж үзүүдэхийг ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр, үйлчилгээнд санал болгох;

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтран ажиллаж ХДХВ/ДОХ-ын талаарх мэдээллүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ойлгомжтой эсэхийг баталгаажуулж энгийн зарим зүйлүүдийг хийхийг ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр, үйлчилгээнд зөвлөх. Тухайлбал боловсрол олгох үйл ажиллагаа явуулах үедээ хараагүй хүмүүст бэлгэвчийг бариулж, үзүүлэх хэрэгтэй. Тэгж байж тэд ямар зүйл болох, юунд хэрэглэдэг болохыг мэднэ;
- Эрсдэлд байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ХДХВ/ДОХ-ын талаарх боловсролын материал, мэдээллийг өгөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтран ажиллаж, ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр, үйлчилгээг мэдээллийн материалуудаа хүртээмжтэй болгоход нь зөвлөгөө өгөх. Тухайлбал, сонсголгүй хүмүүст бичгээр бичих, дохионы хэлний орчуулга шаардлагатай, хараагүй хүмүүс Брайл бичиг эсвэл соронзон хальс шаардлагатай, оюуны бэрхшээлд зураг шаардлагатай байж болох юм;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтран ажиллаж, ерөнхий хүн амд зориулсан мэдээлэл, хөтөлбөрт хүрч чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж шинэ хөтөлбөр, үйлчилгээ, материалыг боловсруулах. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулж сургалт зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд үйлчилгээг ойртуулж тээврийн хэрэгслээр үйлчлэх гэх практик туслалцаа үзүүлэх;
- ХДХВ-эерэг байдлын талаар мэдээлэл өгсний дараа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийг тохирох эмчилгээ, асаргаа, тусламж авч байгаа эсэхийг баталгаажуулах.

Жишээ 12 Уганда

Залуу эмэгтэй ХДХВ-ээ бусдын тусламжтай зохицуулж байгаа нь

Угандад сонсголгүй залуу эмэгтэй ХДХВ эерэг эртэй бэлгийн харьцаанд оров. Тэрээр жирэмсэн болж, харин эрэгтэй нь энэхүү харилцаа болон хүүхдэд хариуцлага хүлээсэнгүй. Гэр бүлийн гишүүд нь түүнийг ХДХВ авсан байж болзошгүй гэж үзээд ХДХВ/ДОХ-ын зөвлөх дээр аваачив. Түүний сорил эерэг гарч, ретро вирусын эсрэг эм уув. Одоо залуу эмэгтэй хүүхэд (хүүхэд сорилоор эерэг гараагүй) 2 сайн байгаа бөгөөд ээж нь эмээ үргэлжлүүлэн ууж, ажлаа хийж, гэрийнхээ ажилд тусалж байна. Түүний гэр бүл одоо өөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст болон тэдний гэр бүлд ХДХВ/ДОХ-ын талаарх мэдээлэл, үйлчилгээг өгдөг болсон.

ХДХВ/ДОХ-той амьдарч байгаа хүмүүсийг ХОТСЗ хөтөлбөрт хамруул

ХОТСЗ хөтөлбөрт бүгдийг хамруулахад бүхий л анхаарлаа тавьдаг учир ХДХВ/ДОХ-той хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг анхаарч үзэх ёстой. Зарим ХДХВ/ДОХ-той хүмүүст сэргээн засалт, туслах хэрэгсэл гэх мэтийн тусгайлсан үйлчилгээ шаардлагатай болж болно. ХОТСЗ хөтөлбөр эдгээрийг зохицуулж чиглүүлж чадна.

Чадавх бэхжүүл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд, ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд, эрүүл мэндийн ажилтнууд болон бусад хамт олны гишүүд гэх мэт гол гол хүмүүсийн чадавхыг бэхжүүлж болно. ХОТСЗ хөтөлбөр дараах үйл ажиллагаануудаг зохион байгуулж болно:

- ХДХВ болон хөгжлийн бэрхшээлийн талаарх шийдвэр гаргахдаа эмэгтэйчүүийн үүрэг ролийг бэхжүүлэх үйл ажиллагаануудыг дэмжиж, гарсан санаачлагыг дэмжих;
- ХДХВ/ДОХ-той хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст дэмжлэг үзүүлж, тусалж байгаа хүмүүс (тухайлбал гэр бүлийн гишүүд)-т тохирох сургалт явуулж, дэмжлэг үзүүлэх;
- ХДХВ/ДОХ болон бэлгийн амьдрал, нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн дарамт зэрэг холбогдох асуудлуудын талаар хөтөлбөртөө оруулж, шаардлагатай бол ХТОСЗ хөтөлбөрийн ажилтнуудад нэмэлт сургалт зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ХДХВ/ДОХ-ын үйл ажиллагаанд хамруулах. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ХДХВ/ДОХ-ын сургагч багшаар бэлтгэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтарч ХДХВ/ДОХ-ын сургагч багш, орон нутагт очиж ажиллах ажилтан, эрүүл мэндийн ажилтанд хөгжлийн бэрхшээлийн талаар сургалт зохион байгуулах;
- Хамт олон болон шашны удирдагчдыг хөгжлийн бэрхшээл болон ХДХВ/ДОХ-ын асуудлаар боловсрол олгож, сөрөг хандлагыг өөрчлөх үйл ажиллагаа зохион байгуулж, хамт олны хүрээнд хамруулах ажлыг нь дэмжих;
- Цагдаа, хуульч, шүүгч зэрэг хууль сахиулах байгууллагын ажилтнуудад хөгжлийн бэрхшээл болон ХДХВ/ДОХ-ын асуудлаар болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн аюулгүй байдал, хүний эрхийг хамгаалах хэрэгцээни талаар боловсрол олгох.

Жишээ 13

Сонсголгүй иргэдийн ХДХВ хөтөлбөр

Зарим оронд сонсголгүй иргэд ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Эдгээр хөтөлбөрүүд нь сонсголгүй иргэдэд ойлголт нэмэгдүүлэх, амьдралын аюулгүй хэв маягийг заадаг. Тэд мөн ХДХВ-ийн байгууллагуудын болон засгийн газрын хөтөлбөрүүдэд ХДХВ-ийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээх арга замуудыг ихэсгэх хэрэгцээний талаарх ойлголтыг өгдөг.

Сүлжээ, түншлэл бий болго

Хөгжлийн бэрхшээл, ХДХВ/ДОХ хоёр хоорондоо харилцан холбоотой (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ХДХВ/ДОХ авах эрсдэлтэй, ХДХВ/ДОХ-той хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй болох магадлалтай) учир хөгжлийн бэрхшээл, ХДХВ/ДОХ-ын гол гол хүмүүсийн хооронд сүлжээ, түншлэл бий болгох хэрэгтэй. ХОТСЗ хөтөлбөр дараах арга хэмжээнүүдийг авах ёстой:

- ХДХВ/ДОХ-ын талаарх уулзалт, өдөрлөг дээр хөгжлийн бэрхшээлийн асуудлыг тусгах, үүний нэгэн адил ХОТСЗ хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж буй уулзалт, өдөрлөг дээр ХДХВ/ДОХ-ын төлөөлөгчдөөс урих;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ХДХВ/ДОХ-ын талаарх мэдээлэл түгээх стратеги боловсруулах, ХДХВ/ДОХ-ын ажилтнуудад хөгжлийн бэрхшээлийн талаарх боловсрол олгоход хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтарч ажиллах;
- ХОТСЗ хөтөлбөрийн сайн мэддэг хөгжлийн бэрхшээл, сэргээн засалтын талаарх туршлагыг ХДХВ/ДОХ-ын сүлжээтэй хуваалцаж, хөгжлийн бэрхшээлийн талаарх сургалт явуулж, сэргээн засаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мөн ХДХВ авах эрсдэлтэй талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх;
- ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр, үйлчилгээг өөрийнхөө эзэмшсэн чадвар, мэдлэгийг ХОТСЗ хөтөлбөр болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хуваалцахыг урих. Ингэснээр тэд өөрсдийн ажилтан, гишүүд, үйлчлүүлэгчийнхээ хэрэгцээнд хариу үзүүлж чадна;
- ХОТСЗ хөтөлбөр, ХДХВ/ДОХ-ын хөтөлбөрийн хооронд зуучлалын тогтолцоог бий болгох.

Олон салбарын хамтын ажиллагааг дэмжих

Хөгжлийн бэрхшээл, ХДХВ/ДОХ хоёр хоёулаа хөгжлийн асуудлууд юм. Ядуурал, буруу ойлголт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, боловсрол олох хүртээмж муу, амьдрал зохиох боломж бага гэх мэт тэгш бус байдлууд аль алинд ижил төстэй байдаг. Тиймээс ХОТСЗ хөтөлбөр хөгжлийн бэрхшээл болон ХДХВ/ДОХ-ын талаар стратегиа боловсруулахдаа бүх салбарыг хамруулах нь чухал. Эрүүл мэнд, Боловсрол, Амьжиргаа, Нийгмийн болон Эрх мэдэлжүүлэх бүрэлдэхүүн хэсгүүд иж бүрэн үйл ажиллагаануудыг санал болгож байгаагаас заримыг нь дурдвал:

- Орон нутагт болон салбар бүрт гардаг хөгжлийн бэрхшээл болон ХДХВ/ДОХ—ын талаарх буруу ойлголт, ялгаварлан гадуурхалттай тэмцэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн боловсрол болон боловсрол эзэмших эрхийг хөхүүлэн дэмжих, мөн орчин нь хамруулсан, хүртээмжтэй байх (Боловсрол бүрэлдэхүүн хэсэг товхимолыг уншина уу).
- ХДХВ/ДОХ-той хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд амьжиргааны боломжуудыг хүртэхийг баталгаажуулах (Амьжиргаа бүрэлдэхүүн хэсэг товхимолыг уншина уу).
- ХДХВ/ДОХ-той хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн албан болон албан бус хамгааллын схемээс хүртэх боломжийг баталгаажуулах (Амьжиргаа бүрэлдэхүүн хэсэг товхимолыг уншина уу).
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бэлгийн дарамтанд өртөхгүй байх/урьдчилан сэргийлэх механизм, хөтөлбөрт хамрагдах боломжийг баталгаажуулах (Нийгмийн бүрэлдэхүүн хэсэг товхимолын Холбоо харилцаа, гэрлэлт, гэр бүл бүлэг болон Шударга шүүхээр шүүлгэх бүлгийг уншина уу).

Ажлын байрны ХДХВ/ДОХ-ын талаарх бодлогыг хэрэгжүүлэх

ХДХВ/ДОХ нь ажлын байрны асуудал байдаг. Олон оронд ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд, тэдний гэр бүлийн гишүүд ХДХВ/ДОХ авах эрсдэлтэй эсвэл авч

болдог. Тиймээс

- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд ХДХВ-ийн халдвар авах боломжийг багасгахын тулд;
- ХДХВ-тэй ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан эсвэл гэр бүл ХДХВ/ДОХ-тойн улмаас түүнээс халдвар авсан хүмүүсийг сайн дэмжихийн тулд;
- Ажлын байран дээр гарч болох буруу ойлголт, ялгаварлан гадуурхалтыг арилгахын тулд;

ХОТСЗ хөтөлбөр ажлын байрны бодлого баримтлах ёстой.
ХДХВ/ДОХ-н бодлогод дараах зүйлүүдийг хамруулсан байх ёстой: ХДХВ/ДОХ авсан хүмүүсийн эрхийг хамгаалах; мэдээлэл, боловсрол, сургалт зохион байгуулж урьдчилан сэргийлэх; ажилтнууд, тэдний гэр бүлийн гишүүдэд асрах, дэмжих.

Бүгдийг хамруулсан үндэсний бодлого, хөтөлбөрийг дэмж

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ХДХВ/ДОХ-ын талаарх баримталж буй бодлого, хөтөлбөрт ихэнхдээ хамрагдаж чаддаггүй учир ХОТСЗ хөтөлбөр өөрчлөлт хийхийн тулд лобби, нөлөөллийн ажлуудыг бусад хүмүүстэй хамтрах хэрэгтэй. Тухайлбал, ХДХВ-ийн хөтөлбөрүүдэд ижил тэгш хамрагдах, ДОХ-ын бодлого, стратеги төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бүрэн дүүрэн оролцохыг уриалж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын нэгдсэн холбоо, ХДХВ/ДОХ-той хүмүүсийн байгууллагууд, засгийн газрын бус байгууллагууд, ХДХВ, ДОХ-ын үйлчилгээнүүд, судлаач нар, идэвхтнүүд болон бусад иргэд хамтран 2007 онд Африкт Хөгжлийн бэрхшээл, ХДХВ, ДОХ-ын талаарх кампанит ажлыг зохион байгуулсан.

Жишээ 14 Өмнөд Африк

Шинэ түүхэн үе

Өмнөд Африкт анх удаа 2007-2009 оны ДОХ-ын үндэсний стратеги төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулсан. Энэ нь засгийн газар, хөгжлийн бэрхшээлийн идэвхтэй байгууллагууд, болон Өмнөд Африкийн ДОХ-ын үндэсний зөвлөл хамтарч ажилласны үр дүн юм.

Ашигласан материалууд

- Hanass-Hancock J, Nixon SA. The fi les of HIV and disability: past, present and future. Journal of theInternational AIDS Society, 2009, 12(28):1–14 (www.jiasociety.org/, accessed 30 March 2010).
- Groce N. HIV/AIDS and individuals with disability. Health and Human Rights, 2005, 8(2):215–224 (http://v1.dpi.org/lang-en/resources/details?page=526, accessed 30 March 2010).
- Groce N. HIV/AIDS and people with disability. The Lancet, 2003, 361:1401–1402 (http://globalsurvey.med.yale.edu/lancet.html, accessed 30 March 2010).
- UNAIDS, WHO and OHCHR policy brief: disability and HIV. Geneva, UNAIDS/ World Health Organization/Office of the United Nations High Commissioner for Human Rights, 2009 (www.who.int/disabilities/jc1632_policy_brief_disability_en.pdf, accessed 30 March 2010).
- HIV/AIDS higher among disabled. International Disability and Development Consortium (undated)(www.includeeverybody.org/cs-hiv.php, accessed 30 March 2010).

- Rusch M. et al. Impairments, activity limitations and participation restrictions: prevalence and associations among persons living with HIV/AIDS in British Columbia. Health and Quality of Life Outcomes, 2004, 2:46.32 cBr gUIdelInes > 7: sUPPlementarY Booklet
- Stigma and discrimination. UNAIDS, 2009 (www.unaids.org/en/PolicyAndPractice/StigmaDiscrim/default.asp, accessed 30 March 2010).
- Disability and HIV/AIDS: at a glance. Washington, DC, World Bank, 2004 (http://web.worldbank.org/WBSITE/EXTERNAL/TOPICS/EXTSOCIALPROTECTION/EXTDISABILITY/0,,contentMDK:20208464~menuPK:488268~pagePK:148956~piPK:216618~theSitePK:282699,00.html, accessed 30 March 2010).
- Rohleder P et al. HIV/AIDS and disability in Southern Africa: a review of relevant literature. Disabilityand Rehabilitation, 2009, 31(1):51–59.
- Groce N. HIV/AIDS & disability: capturing hidden voices, global survey on HIV/AIDS and disability.New Haven, Yale University, 2004 (http://web.worldbank.org/WBSITE/EXTERNAL/TOPICS/EXTSOCIALPROTETION/EXTDISABILITY/0,,contentMDK:20208464~menuPK:488268~pagePK:148956~piPK:216618~theSitePK:282699,00.html, accessed 30 March 2010).
- Yousafzai AK et al. Knowledge, personal risk and experiences of HIV/AIDS among people with disabilities in Swaziland. International Journal of Rehabilitation Research, 2004, 27:247–251.
- Disability and HIV & AIDS in Mozambique: a research report by Disability and Development Partners April 2008. London, Disability and Development Partners, 2008. (www.reliefweb.int/rw/RWFiles2008.nsf/FilesByRWDocUnidFilename/EDIS-7J7PFZ-full_report.pdf/$File/full_report.pdf, accessed 30 March 2010).
- Yousafski A, Edwards K. Double burden: a situation analysis of HIV/AIDS and young people with disabilities in Rwanda and Uganda. London, Save the Children, 2004. (http://v1.dpi.org/files/uploads/1600_DoubleBurden.pdf, accessed 30 March 2010).
- HIV, AIDS and disability. Ottawa, Interagency Coalition on AIDS and Development (ICAD), 2008 (www.aidslex.org/site_documents/DB-0038E.pdf, accessed 30 March 2010).
- The ILO and HIV/AIDS. Geneva, International Labour Organization (undated) (www.ilo.org/public/english/protection/trav/aids/aboutiloaids.htm, accessed 30 March 2010).
- Disability and HIV & AIDS. The Africa campaign on disability and HIV & AIDS (www.africacampaign.org,accessed 10 August 2010).

Уншихыг зөвлөж буй материалууд

Bridging the gap: a call for cooperation between HIV/AIDS activists and the global disability movement. Tataryn
M, 2005 (http://v1.dpi.org/lang-en/resources/details.php?page=325, accessed 30 March 2010).
International guidelines on HIV/AIDS and human rights, 2006 consolidated version. UNAIDS, 2006 (http://data.unaids.org/Publications/IRC-pub07/jc1252internguidelines_en.pdf?preview=true, accessed 30 March 2010).
MacNaughton G. Women's human rights related to health-care services in the context of HIV/AIDS

Хамт олонд түшиглэсэн сэргээн засалт ба уяман

Танилцуулга

Уяман бол маш удаан хугацаанд оршин тогтнодог архаг халдварт өвчин юм. Уяман нь нянгаас үүсдэг бөгөөд хэрэв эмчлэхгүй бол улам цааш өсч арьс, мэдрэл, мөч, нүдэнд байнгын гэмтэл учруулдаг. 2008 онд ойролцоогоор 249000 шинэ тохиолдолд бүртгэгддэг байсан. Уяманд маш үр дүнтэй анагаах эмчилгээ гарч ирсний үр дүнд ойролцоогоор 3 сая орчим уяман өвчнөөс үүдэлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс амьдарч байна гэсэн тооцоо байдаг.

Уяманг үр дүнтэй анагаах эмчилгээ гарахаас өмнө нийгэм энэхүү өвчнөөс маш их айж, ийм өвчтэй хүмүүс ялгаварлан гадуурхагдаж, тэдний талаар буруу ойлголттой байсан. Тэдний ихэнхийг гэр бүлээ орхиж явахыг хүчилж, хуарагнан амьдруулж, хамт олноос тусгаар байлгаж, ямар ч үйлчилгээ, тусламжгүйгээр орхидог байсан. Тэднийг тусгаар байлгаснаас тэднийг буруу ойлгож эхлэхэд хувь нэмруу оруулсан. Эмчилгээ, мэс засал гарч ирсний үр дүнд институтэд түшиглэсэн энэхүү хандлага нь хоцрогдсон – одоо уямантай хүмүүс гэр бүл, хамт олныхоо дунд байж, ерөнхий эрүүл мэндийн үйлчилгээнд уяман өвчин орж байна.

Уяман өвчний үр дүнтэй эмчилгээтэй болж, уяман өвчнийг ерөнхий эрүүл мэндийн үйлчилгээнд оруулж, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх кампанит ажил зохиодог хэдий ч уяман өвчтэй хүмүүсийн талаарх буруу ойлголт том асуудал болон байсаар л байна. Одоог хүртэл олон хүмүүс нийгэмд орж чадахгүй ХОТСЗ хөтөлбөр зэрэг бусад үйлчилгээг авахдаа хүндрэлтэй байсаар байна. Мянга мянган уяман өвчтэй хүмүүст сэргээн засалтын үйлчилгээ хэрэгтэй байдаг боловч тэрхүү үйлчилгээ нь бараг байхгүй байна.

ХОТСЗ хөтөлбөр нь уяман өвчтэй хүмүүст ч гэсэн ижил үйлчилж байх ёстой стратеги. ХОТСЗ хөтөлбөр болон орон нутагт уяман өвчтэй хүмүүсийг хамруулахад хийж болох үйл ажиллагаануудыг санал болгож байна. Уяман өвчний үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрсдийнхөө үйл ажиллагаанд оролцуулахын чухлыг ойлгуулахад энэхүү бүлэг тус болно гэж найдаж байна.

Жишээ 15 Энэтхэг

Шиврао

Шиврао Энэтхэгийн өмнөд хэсэгт байдаг Карнатака мужийн Мандя дүүргийн жижигхэн тосгонд амьдардаг. Түүний гэр бүлийн гурван хүн уяман өвчтэй бөгөөд бүгд түүнээсээ болоод хөгжлийн бэрхшээлтэй болсон. 1999 онд түүнийг 15 настай байхад нүүрэн дээр нь бөөрөнхий улаан толбо гарч ирэв. Нэг өдөр орон нутгийн эрүүл мэндийн Maria Olivia Bonaldo (МОВ) хэмээх хөтөлбөрийн уямангийн ажилтан Амбужа Шивраогийнд ирж түүний толбыг харж, уяман өвчин байх магадлалтай гэж тооцож түүнийг Мандягийн иргэний эмнэлэгт авчирч оношилж, эмчилгээг эхлэв. Шивраог уяман өвчний эмчилгээ хийлгэж байгааг түүний сургуулийнхан сонсож, багш нь түүнийг дахиж ирэхгүй байхыг сануулав.

Амбужа Шивраогийн гэрт давтан үзлэг хийхээр ирээд түүнд тохиолдсон зүйлийн талаар сонссоныхоо дараа сургуулийн багштай уулзахаар явав. Шивраог эмчилгээ хийлгэж байгаа, бусад хүүхдэд энэ нь халдахгүй талаар тайлбарлан Шивраог буцаад сургуульдаа суулгахыг хүсэв. Гэсэн ч багш нь итгэхгүй, эмнэлгээс гэрчилсэн бичиг авчрахыг хүсэв. Амбужа Шивраотай хамт Иргэний эмнэлэг дээр очиж, эмчээс тэрхүү бичгийг авч, эцэст нь Шивраог сургуульд нь буцааж оруулав.

2001 онд МОВ орон нутгийн эрүүл мэндийн хөтөлбөр ХОТСЗ хөтөлбөрийг эхлүүлсэн бөгөөд Амбужа түүний анхны ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнаар сургагдав. Тэрээр сургалтанд хамрагдсаныхаа дараа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрөө өөртөө туслах бүлгийг байгуулсан. Тэрээр Шивраогийн гэрт очиж тэрхүү бүлгийн гишүүнээр орохыг хүсэв. Шивраогийн гэр бүлийнхэн бусад хүмүүс тэднийг хүлээн зөвшөөрөхгүй гэж айж өөрөө өөртөө туслах бүлэгт орохоос айв. Олон дахин ярилцсаны эцэст Шивраогийн ээж өөрөө өөртөө туслах бүлийн уулзалтанд очихоор болов. Тэрээр мөнгө хадгалах үйл ажиллагаанд нэгдэж долоо хоног бүр бага хэмжээний мөнгө хуримтлуулж эхлэв.

Амбужа Шивраогийнд тогтмол эргэлтээ хийсээр байсан бөгөөд Шивраогийн хөл мэдээгүй болж байгааг анзаарч, түүнийг хөлөө хэрхэн сайн арчлах талаар зөвлөгөө өгөв. Мөн Уяман өвчний хөтөлбөрөөс олгодог хөлөө гэмтээхгүй хамгаалах зорилгоор хэрэглэдэг сандаалыг (шаахай) өгөв. 2003 онд Шиврао орон нутгийн ХОТСЗ хөтөлбөрт хөтөлбөрийн ажилтнаар орохоор шийдэв. Энэ ажилд орсноор тэрээр өөртөө итгэх итгэл нь өсч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боломжтой өөр олон боломжуудын талаар мэдэж авсан. Тэр зайн сургалтаар их сургуульд сурсан. Өнөөдөр тэрээр сургуулийн багш, гэрлэсэн, нэг охинтой болсон байна. Мөн тэрээр өөрийнхөө тосгондоо ХОТСЗ хөтөлбөрийнхөө идэвхтэй дэмжигчээр үргэлжлүүлэн ажиллаж байна.

Зорилго

Уяман өвчтэй хүмүүсийн эрхийг хүндэлж, тэдний амьдралын чанарыг сайжруулах тусламж, үйлчилгээг орон нутагт боломжтой болгож, нийгэмд бусдын нэгэн адил тэгш оролцох боломжтой болгох.

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг

ХОТСЗ хөтөлбөрийн үүрэг нь (i) уяман өвчтэй хүмүүсийг үйл ажиллагаандаа хамруулах, (ii) уяман өвчний хөтөлбөр, үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулахад оршино.

Хүсч буй үр дүн

- Уяман өвчтэй хүмүүсийн сэргээн засалтын хэрэгцээг ХОТСЗ хөтөлбөр болон бусад холбогдох зуучлалын үйлчилгээнүүд хангадаг болно.
- Уяман өвчнийг тусгайлан сэргээн засдаг төв болон хөтөлбөрүүд ХОТСЗ хөтөлбөрт хамрагддаг бусад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчилгээгээ үзүүлнэ.
- Уяман өвчтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн талаарх буруу ойлголт, ялгаварлан гадуурхалт буурна.
- Холбогдох бүх гол хүмүүсийн уяман өвчтэй холбоотой асуудлаарх чадвар, мэдлэг сайжирна.

Гол ойлголтууд

Уяман өвчинг ойлгох нь

Уяман гэж юу вэ

Уяман гэж арьс, мэдрэлийг голцуу нэрвэдэг Mycobacterium leprae гэдэг нянгаас үүсдэг өвчин юм. Уяманыг ихэнхдээ нянгийг нь нээсэн Хансен гэх хүний нэрээр Хансены өвчин гэж нэрлэдэг. Энэ нь бүх насны, бүх хүйсийн хүмүүсийг аль алиныг нь нэрвэдэг. Маш удаан явцтай учраас шинж тэмдэг илэртэл олон жил болсон байдаг. Уяман өвчний нэг нийтлэг шинж тэмдэг нь арьсан дээр хэсэг газарт цайвар, улаавтар, эсвэл зэсэн улаан өнгөтэй болдог. Арьсны энэ хэсэг нь хавтгай эсвэл овойсон, тэр хэсэгтээ ямар ч мэдрэмжгүй байдаг. Энэ нь биеийн аль ч хэсэгт гарч болно. Загатнахгүй, мөн ихэнхдээ өвдөхгүй.

Уяманы талаарх нийтлэг ярьдаг яриа

Уяман өвчний талаарх мэдлэг, мэдээлэл цаг өнгөрөх тусам сайжирч байгаа хэдий ч зарим нэгэн цуу яриа байсаар л байна.

- Уяман өвчин эдгэдэггүй. Энэ нь ташаа ойлголт юм. Олон эмийн эмчилгээ (MDT) нь уяман өвчинг анагааж чадна. Сүүлийн 20 жилд 14 гаруй сая хүн эдгэсэн байдаг. ДЭМБ энэхүү олон эмийн эмчилгээ (MDT)-г шаардлагатай оронд хийж байгаа бөгөөд уяман өвчнийг устгахад өөрийн байгууллагын хувь нэмрээ оруулсаар байгаа билээ. Эмчилгээ нь эрүүл мэндийн төвүүд дээр үнэ төлбөргүй хийгддэг.
- Уяман өвчин халддаг. Энэ нь ташаа ойлголт юм. Уяман өвчин өөр хүнд халдаж болох боловч (хамар, амнаас гарах шингэнээр) тийм ч их халддаггүй. Нян тээж байх үедээ уг өвчинг өөр бусад хүмүүст тарааж болно. Харин уяман өвчин нэгэнт тусчихсан хүн халдвар тараахгүй гэж үздэг. Дэлхийн хүн амын 95% нь уяман өвчинг эсэргүүцэх байгалиас заяасан чадвартай байдаг гэсэн тооцоо байдаг. Олон эмийн эмчилгээ (MDT) нь нянг маш үр дүнтэй устгадаг учир хүмүүс олон эмийн эмчилгээ (MDT)-г хийлгээд эхэлсэн л бол ямар ч халдвар тараадаггүй.

Уяман өвчний хариу үйлдлүүд

Уяман өвчтэй зарим хүмүүст “уяман өвчний хариу үйлдлүүд” илэрч болно. Биеийн хэсгийн уяман өвчинд үзүүлж байгаа хариу үйлдэл болохоос биш өвчин улам хүндэрч, эмчилгээ үр дүнгүй болно гэсэн үг биш юм. Өөрөөр хэлбэл хүний бие уяман өвчний нянгийн эсрэг хариу үзүүлж харшлын хариу үйлдлүүд илэрдэг. Ингэснээр өөрийнхөө зөөлөн эдэд гэмтэл учруулж болно. Уяман өвчний нян нь мэдрэл дагадаг учраас уяман өвчний хариу үйлдлийн үед мэдрэл гэмтдэг. Мэдрэлийн гэмтэл маш түргэн явцтай байдаг учир эрт илрүүлж, эрүүл мэндийн төв рүү илгээж, нөхөж болохгүй гэмтэл учрахаас урьдчилан сэргийлэх нь чухал юм. Мэдрэлийн гэмтлийг эрт илрүүлж, эмчлэх нь уяман өвнийг хянах хөтөлбөрийн өмнө тулгардаг асуудал юм. Уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийн 30 хүртэлх % нь мэдрэл гэмтэх, хариу үйлдлийн эрсдэлд ордог.

Уяманаас гардаг эмгэг согогууд

Уяман өвчнөөс үүдэлтэй мэдрэлийн гэмтэл нь өргөн хүрээний эмгэг, согогийг үүсгэдэг. Мэдрэлийн гэмтэл нь мэдрэхүйн согогтой болгодог. Тухайлбал уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийн гар, хөл мэдээгүй болж болно. Мэдрэлийн гэмтэл нь мөн хөдөлгөөний согогтой болгодог. Тухайлбал хүний гар, хөл, нүдний булчин сул болж эсвэл сааждаг. Уяман өвчнөөс болж мэдрэл гэмтсэний улмаас хөлрөх үйлдэл нь алдагдаж арьс маш хуурай болдог. Олон хүмүүст энэ согогоос болж дараагийн хүндрэлүүд гарч ирдэг.

Тухайлбал, гар, хөлний мэдрэхүйгүй болсон хүмүүс өөрсдөө мэдэлгүйгээр өөрийгөө гэмтээсэн байдаг. Гэмтлээс үүдэх өвдөлтийг мэдрэхгүй байгаа учир тэд эмчилгээ хийлгэхгүй байх нь олонтаа. Үүнээс болж халдвар орж, зөөлөн эд, яс гэмтэж, мөчөө алдах ч тохиолдол гардаг. Гар, хөлийн булчин суларч, саажиж, үе мөч хөшиж, гажигтай болдог. Нүдний булчин суларч, эцэс сүүлд нь хараагүй болох, нүдээ анивчихгүй байх, эсвэл шөнө нүдээ бүрэн аниж чадахгүй байснаас нүд хуурайшиж, маш амархан гэмтдэг. Хуурай арьс хагарч, түүгээр нь халдвар үе, ясанд хурдтайгаар тархаж, хөл, гарын хуруу унадаг.

Уяманы үр нөлөө

Үйлдлийн үр нөлөө

Уяман өвчнөөс үүдэн гарах эмгэг согогууд нь тухайн хүнийг өдөр тутмынхаа үйл ажиллагааг хийхэд маш хүндрэлтэй болдог.Тухайлбал, гарынхаа мэдрэмжийг алдсан хүн зүүгээр юм оёх, халбага барих гэх мэтийн энгийн зүйлүүдийг хийхдээ хүндрэлтэй байна. Хөлөө өргөж чадахгүй байгаа (өлмий унжилттай) хүмүүс алхахад хүндрэлтэй байна. Уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийн 20-25% нь хөгжлийн бэрхшээлтэй болдог гэсэн тооцоо байдаг. Уяман өвчинг эрт илрүүлэх, зохих эмчилгээг хийлгэж, цаг тухай бүрд нь шалгуулж байх нь хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх хамгийн гол зүйл юм.

Нийгмийн үр нөлөө

Энэ нь зөвхөн уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүст том асуудал үүсгэж болох бие махбодын эмгэг согог эсвэл үйлдлийн хязгаарлалт биш юм. Харин ч буруу ойлголт бий болох, нийгмээс тусгаарлагдах үр нөлөөнд хүргэдэг. Уяман өвчинд нэрвэгдсэн нь нүдэнд ил харагдаж байгаа хүмүүс ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй, гэрлэж чадахгүй байснаас үүдэн тэд санхүүгийн тусламж болон асрахад бусдаас хамааралтай байдаг. Өөрөө өөрийгөө буруу ойлгох нь нийтлэг үзэгдэл байдаг – тэд өвчнөөсөө болоод өөрийгөө буруутгаж эхэлдэг, ингэснээр өөрсдийгөө ямар ч үнэ цэнэгүй мэт мэдрэмж төрж, итгэл найдвар, зорилго чиглэлээ алддаг. Уяман өвчнөөс илааршсан хүмүүс ч гэсэн энэхүү буруу олйголт, ялгаварлан гадуурхалтын үр нөлөөг амссаар л байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нийгэмд илүү эмзэг, сул байдгийг энэхүү удирдамж цохон тэмдэглэсэн билээ. Уяман өвчтэй эмэгтэйчүүд ч гэсэн энэ ангилалд орно. Нийт хүн амын уяман өвчний талаарх ерөнхий ойлголт, мэдлэг дутмаг байгаагаас (энэ өвчин удамшдаг, халддаг, эсвэл эдгэдэг) холбоо харилцаа, гэрлэлт, гэр бүлд нөлөө үзүүлдэг. Олон эмэгтэйчүүд нөхөртөө хаягддаг, ялангуяа тэд саяхан гэрлэсэн бол хаягдах нь элбэг, эсвэл гэрлэсэн эмэгтэй уяман өвчтэй байвал тэднийг гэрлэхийг бүрэн хориглодог.

Эдийн засгийн үр нөлөө

Уяман өвчин нь хувь хүн, тэдний гэр бүлд эдийн засгийн мэдэгдэхүйц нөлөөг үзүүлдэг. Тэд уяман өвчнөөс үүдэн гарсан эмгэг согогоосоо болоод ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй эсвэл ажлаа үргэлжлүүлэн хийх боломжгүй болдог. Мөн уяман өвчний талаар буруу ойлголтоос үүдээд ажлаасаа гарахад хүрдэг. Тухайлбал, хүмүүс уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсээс хоол хүнс, бараа бүтээгдэхүүн худалдан авах дургүй байдаг. Учир нь хүмүүс халдвар авахаас айдаг. Мөн эмчилгээтэй холбоотой зардлууд гардаг. Эмийн эмчилгээ нь үнэгүй хэдий ч буурай хөгжилтэй оронд эрүүл мэндийн тусламж нь үргэлж тээврийн зардал, мөн цалингийн асуудалтай холбоотой байдаг. Эмнэлэгт хэвтэх эсвэл хөлөө хамгаалах гутал, ортопед гутал эсвэл хиймэл мөч худалдаж авах гэх мэт нэмэлт эмчилгээний зардал гарч болно. Олон хүмүүс эдгээр зарлуудаас болоод үйлчилгээг бүрэн хүртэж чаддаггүй. Түүнээс болж тэдгээр хүмүүст хоёрдогч хүндрэлүүд үүсч хөгжлийн бэрхшээлийн үр нөлөө нь улам ихэсдэг.

Уяманы колониуд буюу хуарагнуулсан суурингууд

Хэдэн арван жилийн өмнө уяман өвчнийг үр дүнтэй эмчилж, анагааж чаддаггүй байх үед уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг уяманы колонид тусгаарлан байрлуулдаг байсан. Үүнийг ихэнхдээ хуулиар тусгаарладаг байсан. Харин үр дүнтэй эмчилгээ бий болмогч эдгээр колониудын ихэнх нь хаагдсан боловч зарим оронд энэ нь хэвээр байдаг. Зарим нь ийм газар удаан хугацаагаар амьдарсан байдаг учир гэр бүлийнхэнтэйгээ ямар ч холбоогүй харилцаагүй болсон байдаг. Хүнд хөгжлийн бэрхшээлтэй тэдгээр хүмүүс гуйлга гуйж амьдардаг.

Жишээ 16 Энэтхэг

Уяманы колониуд

Энэтхэгт уяман өвчинд нэрвэгдсэн маш их хэмжээний хүн ам байдаг. 2005 онд уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийн нэгэн байгууллага Энэтхэгт байдаг уяманы колониудын талаар үндэсний хэмжээнд судалгаа хийсэн. Судалгаагаар 700 уяманы колони үлдсэн ба ойролцоогоор 200.000 уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд эдгээр колониудад амьдарч байсан. Эдгээрээс 25.000 орчин хүн нь гуйлга гуйн амьдарч байв. Ихэнх колониудад бие засах газар байхгүй, ундны ус байхгүй, ойрхон зам байхгүй, боловсрол олгох газар байхгүй байв. Эргэн тойрных нь хүмүүс эдгээр колониудад амьдарч байгаа хүмүүсээс цэрвэж, үүний үр дүнд олон нийтийн тээврийн хэрэгсэл, болон бусад нийтийн үйлчилгээний газрууд тэднийг оруулахгүй байх хүндрэлүүд гарсан байна.

Засгийн газар болон засгийн газрын бус байгууллагууд уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг хамт олондоо оруулахад дэмжлэг үзүүлж, тэдний эрхийг таниулж, буруу ойлголт, ялгаварлан гадуурхах байдлыг тэдэнтэй хамтарч ажиллаж арилгах нь чухал юм. Энэ үйл явцад ХОТСЗ хөтөлбөр ч гэсэн үүрэг хүлээж оролцож болно. Хэрэв тухайн хүмүүс нь өөрсдийн амьдарч байсан колонио орхиж явахгүй хүсэлгүй тохиолдолд ХОТСЗ хөтөлбөр тэднийг эргэн тойрныхоо хүмүүстэй эвтэй найртай амьдрахад тусалж, колониудыг аажмаар нээж бусад хүмүүс ч амьдрах боломжтой болгох хэрэгтэй. Дэлхийн дээр уяманы колониудыг аажмаар энгийн тосгон болгон хувиргасан олон жишээнүүд бий.

Жишээ 17 Бразил

Засгийн газрын дэмжлэгтэйгээр өсч дэвжив

1980-аад оны сүүлд баруун хойд Бразилын Мануст байдаг уяманы колонийг хааж, уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг Lago de Aleixo хотод авчран суурьшуулав. Lago de Aleixo хотод тэр үед ундны ус байхгүй, сургууль байхгүй, дэд бүтэц маш муу хөгжсөн байв. Орон нутгийн сүмийн тусламжтайгаар уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүс хамтарч дээрх асуудлуудыг шийдэхээр хоршоо байгуулав. Тэд эхлээд тоосгоны үйлдвэр барьж, ус нийлүүлэх системээ хийв. Хамт олон улам хүчтэй болж, тахины аж ахуй эрхэлж, ресторан, сургуультай болов. Хамт олны тоо ч өсч, засгийн газар дэд бүтэц, үйлчилгээнүүдийг бий болгож, бусад хүмүүс аажмаар нүүн ирж суурьшиж эхлэв. Одоо Lago de Aleixo том хот болж, түүнийг уяман өвчтэй хүмүүс бий болгож байсныг олон хүмүүс мэдэхгүй болсон билээ.

Уяман болон ХОТСЗ хөтөлбөрийг интеграцчилах нь

Уяман өвчин бага тархалттай, газар бүрт байдаггүй хэдий ч уяман өвчнийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлийг асрах, сэргээн засах зэрэг үйлчилгээнүүдийн 21-р зуунд тогтвортой явуулах шаардлагатай байна.

Өмнө нь эдгээр үйлчилгээнүүдийг тусгайлж үзүүлдэг байсан бол харин одоо ерөнхий эрүүл мэндийн тогтолцоонд оруулсан нь хамгийн чухал стратеги болсон гэж үздэг. Мөн сэргээн засалтын үйлчилгээ үзүүлэх аргад нөлөөлсөн.

Уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүст сэргээн засалтыг үзүүлэхдээ “ерөнхий” сэргээн засалтын үйлчилгээнээс гадуур үзүүлдэг байсан. Тухайлбал, олон олон улсын болон үндэсний засгийн газрын бус байгууллагууд уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүст тусгайлан зориулсан сэргээн засалтын үйлчилгээг (эрүүл мэндийн болон нийгэм эдийн засгийн сэргээн засалт) үзүүлдэг. Мөн ХОТСЗ хөтөлбөр гэх мэт сэргээн засалтын үйлчилгээг үзүүлдэг үйлчилгээнүүд нь уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг хамаардаггүй. ХОТСЗ хөтөлбөр уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг хамруулдаггүйн гол шалтгаан нь уяман өвчний талаарх буруу ойлголт болон уяман өвчний тусгайлсан хөтөлбөрүүд хэрэгжүүлдэгт оршдог.

Уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүст тусгайлан зориулсан сэргээн засалтын үйлчилгээг бусад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэхийг дэмжиж байгаа. Тэдний эзэмшсэн чадвар, нөөц бололцооноос илүү олон хүмүүс ашиг хүртэж болно. ХОТСЗ хөтөлбөрийн хувьд энэ нь зуучлах төв болж болно. Тухайлбал ХОТСЗ хөтөлбөр хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийг уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүст үйлчилдэг байсан ортопедийн цех рүү илгээж болно. ХОТСЗ хөтөлбөр энэ бүлгийн хүмүүст маш холбогдолтой стратеги учир хөтөлбөр өөрийнхөө үзүүлдэг үйлчилгээгээ уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүст үзүүлэх хэрэгтэй. ХОТСЗ хөтөлбөр нь сэргээн засалт шаардлагатай уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүс сонгох боломжтой стратегитай байх ёстой.

Санал болгож буй үйл ажиллагаанууд

ХОТСЗ нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүст зориулсан стратеги учир энэхүү удирдамжинд санал болгож байгаа үйл ажиллагаануудын ихэнхийг уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүс мөн хэрэглэж болно. Тиймээс ХОТСЗ хандлагын матрицад байгаа эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа, нийгмийн, эрх мэдэлжүүлэх гэсэн гол бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгэн адил энэ хэсгийг бас унших шаардлагатай. Мөн хамт олонд түшиглэсэн сэргээн засалт болон уяман өвчний талаарх ДЭМБ/Олон улсын уяман өвчний холбооны удирдамж зэрэг гарын авлагууд нь ХОТСЗ хөтөлбөрийн менежер болон ажилтнуудад хийж болох үйл ажиллагаануудыг санал болгосон байдаг.

Уяман өвчтэй хүмүүсийг ХОТСЗ хөтөлбөрт оруул

Уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүст тулгардаг асуудлуудыг шийдвэрлэхдээ хөгжлийн чиг хандлагын талаас нь харж байх хэрэгтэй. Тиймээс ХОТСЗ хөтөлбөр уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг хөгжлийн хөтөлбөрүүд болон үйл ажиллагаанаас ашиг хүртээхийн тулд бүх салбаруудатай хамтарч ажиллах хэрэгтэй. Уяман өвчнөөс үүдэлтэй хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд тусгаарлагдаж, ядууралд илүүтэйгээр өртддөг учир ХОТСЗ хөтөлбөр тэд нарыг хөтөлбөрийн үйл ажиллагааууд оролцуулж, мөн ашиг хүртэх боломжийг нээж өгөх хэрэгтэй.

Эрүүл мэнд

Уяман өвчнөөс үүссэн эмгэг согогтой хүмүүст 1) мэдрэлийн функцийг хамгаалах, 2) үений хөдөлгөөнийг хамгаалах, 3) хараг хамгаалж үлдэх, 4) өөрийгөө асрах/удирдах аргад суралцах, 5) хамгаалах гутал өмсөх, 6) туслах хэрэгслүүдийг хэрэглэх гэх мэтийн эрүүл мэндийн тусламж шаардлагатай. ХОТСЗ хөтөлбөр дараах эрүүл мэндийн тусламжуудыг үзүүлж чадна:

- Орон нутагт байгаа эрүүл мэндийн үйлчилгээнүүдийг уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд танилцуулж, тэдгээр үйчилгээг авдаг байх;
- Хүмүүс олон эмийн эмчилгээ (MDT)-гээ дуустал нь тогтмол хэрэглэж, уяман өвчний хариу үйлдлүүдийн талаар мэдээлэл олгож, тэд өөрсдийгөө илрүүлж, яаралтай эмчилгээгээг хийлгэдэг байхыг сургах;
- уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүс тогтмол уулзаж, туршлагаа хуваалцаж, өөрийгөө асрах/удирдах үйл ажиллагааны талаар суралцах, эмгэг согогоос урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авч сурах зэргийг хийх боломжтой өөрөө өөртөө туслах бүлэг байгуулахыг дэмжих (Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг товхимол: Урьдчилан сэргийлэх хэсгийг уншина уу);
- Мэдрэхүйн алдагдалтай хүмүүст гар, хөл, нүдээ хэрхэн хамгаалах талаар зөвлөгөө өгөх. Тухайлбал халуун тогоо барихдаа бээлий өмсөх. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй хамт олны түвшинд ажиллах гарын авлага зэрэг гарын авлагууд нь мэдрэхүйн алдагдалтай хүмүүс осол гэмтлээс болон үүсэх гажгаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаар илүү мэдээллээр хангадаг;

- Шаардлагатай үед тусгай гутал гэх мэтийн туслах хэрэгслийг авч, түүнийг засч чаддаг байх (Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг товхимол: Туслах хэрэгсэл хэсгийг уншина уу);

Жишээ 18 Этиоп

Өөрөө өөртөө бүлэгт орсноор өөрийгөө хүндэлж, эрхэмсэг оршихуй

ALERT нь уяман өвчний нарийн мэргэжлийн туслалцаа үзүүлдэг Этиопийн Аддис Абаба-ын эрэг дээр байдаг эрүүл мэндийн газар юм. 1995 онд ALERT -ын ажилтнууд эмнэлгээр болон хөдөө орон нутгийн клиникээр шархаа цэвэрлүүлдэг (хөлний шарх) хүмүүсийн тоо эрүүл мэндийн боловсрол олгодог ажлаас ч илүү өсч байгаа талаар сэтгэгдлээ илэрхийлэв. Энэ нь ALERT-д ачаалал үүсч, шарханд хэрэглэдэг материалууд худалдаж авах санхүүгийн нөөцөө хязгаарлаж эхлэв. Үүний хариу үзүүлэлт болгох ALERT шархаа өөрөө цэвэрлэх, хянахад хариуцлага хүлээлгэх өөрөө өөрийгөө асрах бүлгийг байгуулжээ. 1999 он гэхэд ийм бүлэг 72-т хүрч, эерэг үр дүнгүүд гарч эхэлжээ. Тухайлбал, шархлах тоо багасч, нийгэмд оролцох оролцоо нэмэгдэж, өөрийгөө хүндлэх, эрхэмсэг оршихуй нь сайжирсан гэж тайландаа бичжээ.

Боловсрол

Хүүхдүүд уяман өвчинд нэрвэгдсэн эсвэл тэдний ээж, аав, хамаатан садан нь уяман өвчтэй учир энэ асуудалд өртдөг байж болно. Үүнээс болж тэд сургуульд явж чадахгүй, сургууль завсардаж, найзуудаасаа хөндийрч, гэр бүлийнхэн нь тэднийг нууж, эсвэл ажил хийж мөнгө олох шаардлага гардаг. Хүүхдүүдийг (эсвэл насанд хүрсэн хүмүүсийг) хамт олныхоо дунд боловсрол эзэмшихэд нь ХОТСЗ хөтөлбөр дэмжиж чадна. Тухайлбал ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан уяман өвчинд нэрвэгдсэн оюутан сурагчдын тааарх хандлагыг өөрчлөхийн тулд сургуулийн багш болон эцэг эхчүүдтэй уулзаж, уяман өвчний талаар ойлголт өгч болно. Хийж болох үйл ажиллагаануудыг Боловсрол бүрэлдэхүүн хэсэг товхимолоос харна уу.

Амьжиргаа

Уяман өвчтэй хүмүүс маш ядуу байдаг. Мөн буруу ойлголт, ялгаварлан гадуурхалт, уяман өвчнөөс үүдсэн хөгжлийн бэрхшээл зэрэг нь тэднийг ядуурлаас гарах ажил хөдөлмөр хийх боломжийг нь хааж байдаг. Чадвар эзэмшиж, өөрийн дуртай ажлаа хийх нь нийгэмд орохын эхлэлийн цэг байх болно. Мөн бусдаас тусгаарлагдсан, бусдаас хараат, хөгжлийн бэрхшээлтэй ихэнхдээ уялдан гардаг ядуурлын циклээс гарах механизм нь болдог. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр бүлдээ санхүүгийн хувь нэмэр оруулдаг болбол тэдний гэр бүл дэх оролцоо нэмэгддэг. Тухайлбал шийдвэр гаргах үйл явцад тэднийг оролцуулдаг болдог. ХОТСЗ хөтөлбөрт хүмүүст туслах маш олон арга байна. Тухайлбал тэд зуучлагчийн үүрэг гүйцэтгэж, уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг ажилд авах сайн ажил олгогч нарт мэдээлэл олгож болно. Хийж болох үйл ажиллагаануудыг Амьжиргаа бүрэлдэхүүн хэсэг товхимолоос харна уу.

Жишээ 19 Этиоп

Буруу ойлголт, ядуурлыг бууруулахад дорвитой арга хэмжээ авав

Этиопийн Уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийн үндэсний холбоо (ENAPAL) нь эрхэм зэрэг болон өөртөө итгэх итгэлээ дахин олж авахад нь дэмжиж гишүүдийнхээ амьжиргааг сайжруулахад үйл ажлаа зориулдаг. Одоогийн байдлаар холбоо нь Этиопийн 7 мужийн 54 нийгэмлэгийг нэгтгэсэн 20.000 гаруй гишүүдтэй. Ойлголт нэмэгдүүлэх, нөлөөллийн ажил хийх, амьжиргааны төслүүдийн үндэсний болон олон улсын байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлж байна. Амьжиргааны төслүүд нь уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг бусад иргэний нэгэн адил бүтээх чадвартай гэдгийг харуулдаг юм. ENAPAL нь өөрсдийнхөө гишүүдийн орлого нэмэгдүүлэх үйл ажиллагаанд зориулж эргэлтийн сан ажиллуулсан. Мөн гишүүдийнхээ хүүхдүүдэд боловсрол олгож, буруу ойлголт, ядуурлын циклийг эвдэхийн тулд гэр бүлийн гишүүдийг чадавхжуулсан. Мөн холбоо нь уяман өвчинд нэрвэгдсэн эмэгтэйчүүдэд зориулж өөрөө өөртөө туслах бүлгийг зохион байгуулсан. Эдгээр стратегиуд нь амжилттай хэрэгжсэн билээ.

Нийгэм

Уяман өвчний талаарх буруу ойлголт, ялгаварлан гадуурхалт, буруу төсөөлөл нь тухайн газарт байгаа үйлчилгээг хүртэх, хамт олны амьдралд оролцоход үргэлж саад болж байдаг. ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд дараах ажлуудыг зохион байгуулж нийгмийн дундах буруу ойлголтыг багасгахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

- Уяман өвчний талаар эерэг ойлголтыг өгөхийн тулд хамт олны манлайлагч, багш, шашны удирдлагуудтай хамтран ажиллах;
- Уяман өвчний талаар олон нийтийн ойлголт нэмэгдүүлэх кампанит ажлыг зохион байгуулах эсвэл оролцох – жүжигчилсэн тоглолт, үзэсгэлэн, гарын авлага материал тараах зэрэг үйл ажиллагааг орон нутгийн зах, олон нийтийн газар, сургууль дээр зохиож болно;

- Уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, мөн хөгжлийн бэрхшээлгүй хүмүүс хамт оролцож болох спортын эсвэл соёлын хөтөлбөрүүдэд хамтарч оролцох – ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамт олны бусад гишүүдийн нэгэн адил чадвартай гэдгийг нийт хүмүүст харуулах, мөн тэдний эрх гэдгийг мэдрүүлэхэд тус болно.

Эрх мэдэлжүүлэх

Уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүс өөрсдийнхөө эрхийг мэддэг, үйлчилгээ, нөөц бололцооноос хүртэхийн тулд өөрсдийгөө хэрхэн илэрхийлэх талаар мэддэг байх нь чухал. Өөрсдөө байгуулсан байгууллага эдгээр зүйлийг хийхэд хамгийн тохиромжтой, үр дүнтэй арга нь байж болох юм. Дэлхий дээр уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүс өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалсан нийгэмлэг, бүлгийг байгуулсан байдаг. Жишээлбэл: Бразилын Хансены өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг дахин нийгэмшүүлэх хөдөлгөөн (MORHAN), Анголагийн Уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг нийгэмшүүлэх холбоо (APRAL), Энэтхэгийн

Үндэсний Форум. Эдгээр бүлгүүдийн зарим нь нэгдэж холбоо болсон байдаг. Тухайлбал Нийгэмшүүлэх, Эрхэм зэрэг, Эдийн засгийн давуу талын олон улсын нийгэмлэг (IDEA). Зарим хүмүүс орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагад нэгддэг. Эдгээр нийгэмлэгүүд нь чадавхжуулах, эрх мэдэлжүүлэх сургалт, өөр сэдвүүдээр уулзалт зохион байгуулдаг. Тухайлбал Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Олон улсын хурал гэх мэт. ХОТСЗ хөтөлбөр нь уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг өөрөө өөртөө туслах бүлэг болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудад ороход тусалж болно. (Эрх мэдэлжүүлэх бүрэлдэхүүн хэсэг товхимол: Өөрөө өөртөө туслах бүлэг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага хэсгийг уншина уу)

Уяман өвчний хөтөлбөрийг хамруулсан болго

Уяман өвчний сэргээн засалтын хөтөлбөрийг бусад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нээллттэй боломжтой болгохыг ХОТСЗ хөтөлбөр уриалж болно. Ингэснээр маш олон давуу талтай; Уяман өвчнөөс үүддэг буруу ойлголтыг багасгах, одоо байгаа үйлчилгээнээс олон хүмүүст ашиг хүртээхийн тулд уяман өвчний үйлчилгээг бусад салбарт нэвтрүүлэх зэрэгт тусалж болох юм. Уяман өвчний тусгайлсан хөтөлбөртэй, үйлчилгээтэй газарт бусад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэдний үйлчилгээг нээхийн тулд ХОТСЗ-ын стратегийг танилцуулах хэрэгтэй. Эдгээр хөтөлбөрүүдэй сүлжээ байгуулснаар мэдээлэл солилцох, үйлчилгээний давхардлыг арилгах, сэргээн засалтын хэрэгцээнд хариу үзүүлэх шинэ аргуудыг нээж илрүүлэхэд чухал юм.

Чадавх бэхжүүл

ХОТСЗ хөтөлбөр нь хамт олонд түшиглэсэн сэргээн засалтын хамруулахын хандлага руу хөдлөхийн тулд бүх гол хүмүүсийн чадавхийг бэхжүүлэхэр анхаарлаа хандуулах ёстой. Гол хүмүүст ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан, уяман өвчний хөтөлбөр, үйлчилгээний ажилтан, уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд орно. Дараах үйл ажиллагаануудыг санал болгож байна.

- ХОТСЗ хөтөлбөрт уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг хамруулахын тулд ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудыг сургалтанд хамруулах, дахин сургах.
- Уяман өвчний хөтөлбөр, үйлчилгээ нь өөрсдийнхөө ажилтнууддаа ХОТСЗ стратегийн талаар сургалт зохион байгуулах – мөн ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудыг эдгээр сургалтанд мөн хамруулах.
- ХОТСЗ хөтөлбөрт хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст уяман өвчний талаар ойлголт өгөх –уяман өвчтэй хүмүүсийг ХОТСЗ хөтөлбөрт хамрагдахыг хүлээн зөвшөөрөх нь чухал.
- Уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд өөрсдийнхөө өвчинг болон түүнээс урган гарах эмгэг, согогийг удирдаж сургахын тулд сургалт явуулах.
- Орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудад уяман өвчний талаар мэдлэг ойлголт өгч, уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүс ижил тэгш эрхтэй, тэгш боломжтойг хүлээн зөвшөөрөх.

Жишээ 20 Судан

Уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг хүлээн зөвшөөрсөн нь

Суданы Няала-д Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмлэг уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг хамруулдаггүй байв. Leprosy Mission байгууллагын ажилтнууд тэрхүү нийгэмлэгийн гишүүдэд сургалт зохион байгуулж, олон эмийн эмчилгээ хийлгэж хүмүүс ямар ч халдваргүй болох тухайн тайлбарлаж уяман өвчний талаар боловсрол олгосон. Сургалтын тадаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмлэг олон эмийн эмчилгээг эхлэхээр шийдэж, бусад үйлчилгээнүүдийг үзүүлж, уяман өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг гишүүнээрээ элсүүлж авсан.

Ашигласан материалууд

- Leprosy . Geneva, World Health Organization, 2010 (www.who.int/mediacentre/factsheets/fs101/en/index.html, accessed 30 March 2010).
- Disabilities and rehabilitation. In: WHO Expert Committee on Leprosy, seventh report , Chapter 6 (WHO Technical Report Series, No. 874). Geneva, World Health Organization, 1997 (www.who.int/lep/resources/Expert06.pdf, accessed 30 March 2010).
- Guidelines for the social and economic rehabilitation of people aff ected by leprosy . London, ILEP,1999 (www.ilep.org.uk/fileadmin/uploads/Documents/Technical_Guides/sereng.pdf, accessed 30 March 2010).
- WHO/ILEP technical guide on community-based rehabilitation and leprosy . Geneva, World Health Organization, 2007 (www.who.int/disabilities/publications/cbr/cbrleng.pdf, accessed 30 March 2010).
- Singapore , 2007, 36(1):86–87 (www.annals.edu.sg/pdf/36VolNo1Jan2007/V36N1p86.pdf, accessed30 March 2010).
- Guide to eliminate leprosy as a public health problem . Geneva, World Health Organization, 2000 (www.who.int/lep/resources/Guide_Int_E.pdf, accessed 30 March 2010).
- Frist TF. Don’t treat me like I have leprosy! London, ILEP, 2003 (www.ilep.org.uk/fi leadmin/uploads/Documents/Non-ILEP_Publications/dtml.pdf, accessed 30 March 2010).Consensus statement on prevention of disability . Pan American Health Organization, 2006 (www.paho.org/English/AD/DPC/CD/lep-consensus-stmt-pod.doc, accessed 30 March 2010).
- ILEP technical guide. Facilitating the integration process: a guide to the integration of leprosy services withinthe general health system . London, ILEP, 2003 (www.ilep.org.uk/library-resources/ilep-publications/english/, accessed 30 March 2010).
- Learning Guide 4 – How to prevent disabilities in leprosy . London, International Federation of Anti-Leprosy Associations (ILEP), 2006 (www.ilep.org.uk/fi leadmin/uploads/Documents/Learning_Guides/lg4eng1.pdf, accessed 30 March 2010).

- Meima A et al. Dynamics of impairment during and after treatment: the AMFES cohort. Leprosy Review ,2001, 72(2):158–170.
- Finkenfl ugel H, Rule S. Integrating community-based rehabilitation and leprosy rehabilitation servicesinto an inclusive development approach. Leprosy Review , 2008, 79(1):83–91 (www.leprosy-review.org.uk/, accessed 30 March 2010).
- Helander E et al. Training in the community for people with disabilities . Geneva, World Health Organization, 1989 (www.who.int/disabilities/publications/cbr/training/en/index.html, accessed30 March 2010).
- Benbow C, Tamiru T. The experience of self-care groups with people affected by leprosy: ALERT,Ethiopia. Leprosy Review, 2001, 72(3):311–321 (www.leprosy-review.org.uk/, accessed 30 March 2010).
- Ebenso B et al. Impact of socio-economic rehabilitation on leprosy stigma in Northern Nigeria: findingsof a retrospective study. Asia Pacific Disability Rehabilitation Journal , 2007, 18(2):98–119 (www.aifo.it/english/resources/online/apdrj/apdrj207/leprosy_nigeria.pdf, accessed 30 March 2010).
- Convention on the Rights of Persons with Disabilities. United Nations, 2006 (www.un.org/disabilities/,accessed 30 March 2010).
- Cornielje H et al. Inclusion of persons affected by leprosy in CBR. Leprosy Review , 2008, 79(1):30–35(www.leprosy-review.org.uk/, accessed 30 March 2010).

Уншихыг зөвлөж буй материалууд

Infolep Leprosy Information Services. London, ILEP (undated) (www.infolep.nl, accessed 30 March 2010).

International Federation of Anti-Leprosy Associations (ILEP) (www.ilep.org.uk/, accessed 30 March 2010).

ILEP Learning Guide 1 – How to diagnose and treat leprosy. London, ILEP, 2001 (www.ilep.org.uk/fileadmin/
uploads/Documents/Learning_Guides/lg1eng.pdf, accessed 30 March 2010).

Special issue on CBR and leprosy. Leprosy Review, 2008, 79(1) (www.leprosy-review.org.uk/, accessed 30
March 2010).

WHO Goodwill Ambassador's newsletter for the elimination of leprosy. Nippon Foundation (undated) (www.
nippon-foundation.or.jp/eng/leprosy/2006736/20067361.html, accessed 30 March 2010).

Хамт олонд түшиглэсэн сэргээн засалт ба хүн төрөлхтөний хямрал

Танилцуулга

Хүмүүнлэгийн гэдэг нь хэсэг бүлэг хүний эсвэл аливаа хамт олны эрүүл мэнд, аюулгүй байдал, мөн сайн сайхан байхад нь ноцтой аюул учирсан (зэвсэгт мөргөлдөөн, байгалийн гамшиг, халдварт өвчин, өлсгөлөн гэх мэт) үед хэрэгжүүлдэг арга хэмжээ байдаг. Түүнийг даван туулахад хамгаалалт, мөн гаднаас тусламж шаардлагатай байдаг.

Хүн төрөлхтөний хямрал нь осол гэмтэл, амьдралаа алдах, мөн хоол хүнс, ус, орон байр, ариун цэвэр зэрэг үндсэн хэрэгцээгээ авах чадвар буурах зэргээр хүн төрөлхтөнд асар их нөлөө үзүүлдэг. Мөн дэд бүтэц, ургац, орон байр сүйдэж, ажилгүй хүмүүс ихэсч эдийн засгийн нөлөө үзүүлдэг. Хүн төрөлхтөний хямрал нь хөгжлийн бэрхшээлийн салбартай болон хамт олонд түшиглэсэн сэргээн засалтын хөтөлбөртэй холбоотой байдаг. Учир нь энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст маш ихээр нөлөөлдөг тодийгүй тусламж, дэмжлэг шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шинэ үеийг үүсгэдэг.

Сүүлийн жилүүдэд хүмүүнлэгийн салбарт маш олон өөрчлөлт гарч, хүмүүнлэгийн ажлыг илүү үр дүнтэй, үр нөлөөтэй болгох шаардлага гарсаар байна. Энэхүү нэмэлт товхимол нь эдгээр өөрчлөлтүүдээс заримыг нь онцлон дурдах бөгөөд хүн төрөлхтөний хямралын үед ХОТСЗ хөтөлбөрийн гүйцэтгэх үүргийг тодорхой болгож, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг хүмүүнлэгийн үйл ажиллагаанд хэрхэн оролцуулах, хамруулах талаар санал дэвшүүлж байгаа юм.



Жишээ 21 Шри Ланка

Бүх нийтийн хүртээмж

Бүх нийтийн хүртээмж кампанит ажил нь 2004 оны 12-р сарын 26нд Шри Ланкагийн эрэг хавиар болсон цунамигийн дараа хийсэн ажил юм. Үүнийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага (орон нутгийн 18 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг хамардаг үндэсний шүхэр байгууллага), Нуруу нугасны гэмтэлтэй хүмүүсийн нийгэмлэг, Motivation, CBM, John Grooms, Handicap International болон Эрүүл мэндийн яам (Залуучууд, өндөн настан, хөгжлийн бэрхшээлтэй болон дүрвэгсэдийн асуудал хариуцсан хэлтэс) хамтран зохион байгуулсан юм.

Кампанит ажлын зорилго нь цунамигийн тусламжийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангаж, Шри Ланкад дахин сэргээн босгох, сэргээн засалтын ажлуудыг дэмжихэд оршсон. Ялангуяа хүртээмжтэй Шри Ланкаг босгоход - бүх нийтийн барилга байгууламж, тээвэр, ажлын байр, үйлчилгээ, дэд бүтцийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгоход анхаарлаа хандуулсан. Цунамигийн өмнөх Шри Ланкад амьдарч байсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмж гэдэг асуудал тийм ч амархан байгаагүй юм. Харин хамшгийн дараах дахин сэргээн босголт нь энэ хэрэгцээг анхаарч үзэх боломжийг бий болгосон.

Бүх нийтийн хүртээмж хороо байгуулагдан хоёр долоо хоногийн турш хуралдаж, сэргээн засалт, сэргээн босголтыг хариуцсан засгийн газрын удирдлагууд, олон улсын болон төрийн бус байгууллагууд, улсын салбарыг урьж ярилцаж байв. Уулзалтуудын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийн хэрэгцээг хүн бүрийг мэдрүүлж, техникийн зөвлөгөө, нөөц бололцоо, дэмжлэгийг санал болгоход оршсон.

Бүх нийтийн хүртээмж кампанит ажлын үр дүнд сэргээн босголт, сэргээн засалтын ажилд оролцож байгаа байгууллагууд хөгжлийн бэрхшээлийн асуудлаар мэдлэг болов. Хүртээмжийн тогтоол шийдвэр гарч, бүх шинэ барилгуудаа хүртээмжтэй барьж, хүртээмжгүй бүх барилга байгууламжийг тодорхой нөхцөлд хүртээмжтэй болгохоор болов. Бүх нийтийн хүртээмж кампанит ажил нь Шри Ланкад үргэлжлэн хэрэгжиж байгаа бөгөөд одоо хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хөхиүлэн дэмжих, сурах боловсрох, ажил хөдөлмөр эрхлэхэд нь тэгш боломж олгох гэх зэрэг илүү өргөн хүрээнд хамруулахад анхаарлаа хандуулж байна.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг хүмүүнлэгийн үйл ажиллагаанд бэлтгэх, яаралтай үед авах хариу арга хэмжээ, сэргээн босгох үйл ажиллагаанд хамруулах.

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг

ХОТСЗ хөтөлбөрийн үүрэг нь (i) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд болон хамт олныг гарч болох хямралд бэлтгэхэд туслах; (ii) хүмүүнлэгийн хариу арга хэмжээ болон сэргээн босгох үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах; (iii) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг хүмүүнлэгийн тусламж, үйлчилгээтэй холбоход оршино.

Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд хямралд хариу үзүүлэхэд бэлтгэгдэнэ.
- Хүмүүнлэгийн хариу үйлдлийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн үндсэн хэрэгцээг хангана.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүмүүнлэгийн болон сэргээн босголтын хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд хамруулна.
- Хүмүүнлэгийн хямралын дараа дэд бүтцийг дахин сэргээхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгоно.
- Хямралын дараа дахин бий болгох, боловсруулах үйлчилгээ, тусламж дэмжлэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг анхаарч үзсэн, хүртээмжтэй байна.

Гол ойлголтууд

Хөгжлийн бэрхшээл ба хүн төрөлхтөний хямрал

Хүн төрөлхтөний хямралд өртөж эрсдэлд ордог бүлгүүдийн нэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг илүү эмзэг болгодог хэд хэдэн хүчин зүйлүүд байдаг.

Хамруулахгүй байх – хүмүүнлэгийн тусламж үзүүлэх байгууллага, хамт олны оновчгүй бодлого, практик нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулдаггүй байж болно.

Ойлголт, мэдлэг дутмаг байх – болж байгаа зүйлийн талаар анхааруулга, аюул, эрсдлийн талаар мэдээлэл болон хямралын үед, хямралын дараа авах арга хэмжээнүүд бүхий зөвлөгөөг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хэлбэрээр ихэнхдээ хийдэггүй. Тиймээс тэд анхааруулах дохиог хардаггүй, юу хийх, хаашаа явах, хаанаас тусламж авах талаарх зааварчилгааг ойлгодоггүй.

Нийгмийн тусламж, дэмжлэгийн сүлжээ байхгүй байх – гэр бүлийн гишүүд, найз нөхөд, хөршүүдээс үргэлж тусламж дэмжлэг авч байдаг хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүсийн хувьд нийгмийн сүлжээнүүд нь маш чухал юм (Нийгмийн бүрэлдэхүүн хэсэг товхимол: Хувийн туслалцаа хэсгийг уншина уу). Эдгээр сүлжээнүүд нь хямралт нөхцөл байдлын үед ихэнхдээ өртдөг. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс асран хамгаалагч нараасаа тасрах, эсвэл асран хамгаалагч нь гэмтэх эсвэл үхдэг.

Бие махбодын саад бэрхшээл – хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст одоо байгаа саад бэрхшээл нь илүү хурцдаж, эсвэл шинэ саад бэрхшээл үүсэх зэрэг бие махбодын орчин нь хямралын нөхцөл байдалд шижлдэг. Олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хиймэл мөч, таяг, сонсголын аппарат, нүдний шил зэрэг туслах хэрэгслүүдээ алдсанаас болж тусламж дэмжлэг авахад илүү хүндрэлтэй тулгардаг. Тухайлбал тэд хоол хүнс, ус, орон байр, бие засах болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч чадахгүйд хүрдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүмүүнлэгийн үйл ажиллагаанд хамруулах

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хямралын үед их хэмжээгээр өртдөг гэсэн нотолгоо байгаа хэдий ч хүмүүнлэгийн үйл ажиллагаанд хамрагдаж чадалгүй гадна хоцрох явдал их байдаг. Хүмүүнлэгийн бүхий л үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлийг тусгаж өгч байх ёстойг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн 11-р зүйлд цохон тэмдэглэсэн байгаа билээ.

“Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, олон улсын хүний эрхийн хэм хэмжээг оролцуулан олон улсын эрх зүйгээр хүлээлгэсэн үүрэгтэй нийцүүлэн Оролцогч улсууд нь эрсдэл бүхий байдал, тухайлбал зэвсэгт мөргөлдөөн, хүмүүнлэгийн онц байдал, байгалийн гамшиг тохиолдсон үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авна”.

Өртсөн хүмүүсийг оролцуулах нь хямралын үед маш чухал зүйл байдаг. Хүмүүнлэгийн үйл ажиллагаа болон хариу үйлдлийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний төлөөллийн байгууллагууд зөвхөн ашиг хүртэгч төдийгүй түншлэгч байх ёстой. Өөрөөр хэлбэл тусламжийн хөтөлбөрийг үнэлэх, зохиох, хэрэгжүүлэх, мониторинг үнэлэгээ хийх зэрэг бүхий л үйл ажиллагаанд оролцуулах нь чухал юм.

Кластер (бөөгнөрөл) хандлага

2005 оноос хямралын үед үзүүлэх олон улсын хүмүүнлэгийн ажиллагааны үр нөлөөг сайжруулж эхэлсэн. Ерөнхий зорилго нь илүү олон хүнийг цаг хугацаатай уралдан илүү үр дүнтэйгээр илүү олон хүнд хүрч, иж бүрэн хэрэгцээнд суурилан аварч, хамгаалахад оршдог. Хүмүүнлэгийн хариу үйлдлүүдийн гол өөрчлөлтүүдийн нэг нь кластер хандлагыг боловсруулах, хэрэгжүүлэх явдал юм.

Кластер хандлага нь хямралын үед хүмүүнлэгийн тусламж үзүүлдэг салбар (эрүүл мэнд, боловсрол, түр зуур орогнох байр гэх мэт) хоорондын болон салбарын үүрэг, хариуцлагыг тодорхой болгож зохицуулалтыг бэхжүүлдэг. Кластер хандлага нь олон улсын хүмүүнлэгийн ажилтнуудыг илүү зохион

байгуулалттай, тодорхой, мэргэжлийн болгож, засгийн газар, орон нутгийн удирдлага болон орон нутгийн иргэний нийгэмтэй илүү сайн түншилж ажиллах боломжийг олгодог.

Дэлхийн түвшинд 11 кластер байдаг (Хүснэгт 1-ийг харна уу). Кластер бүрийг нэг агентлаг тэргүүлдэг. Тухайлбал дэлхийн эрүүл мэндийн кластерийг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) удирдаж, стандарт, бодлого боловсруулах, хариу үзүүлэх чадавхийг бий болгох, шуурхай дэмжлэгийг үзүүлдэг. Кластер бүрт хүн төрөлхтөний хямралын үед хамтарч ажилладаг агентлаг, байгууллагууд байдаг. Тухайлбал, дэлхийн эрүүл мэндийн кластерт НҮБ-ын Хүүхдийн сан (ЮНИСЕФ), Олон улсын улаан загалмай, улаан хавирган сар нийгэмлэг, Handicap International зэрэг 30 гаруй агентлаг, байгууллагууд ордог.

Тухайн орны түвшинд хүн төрөлхтөний хямрал бий болсон тохиолдолд эдгээр байгууллагууд бүгд, эсвэл тэдний зарим нь идэвхтэй байж болно. Кластерийг өөр өөр агентлагуудын удирдсан салбар гэдэг ч юмуу тэднийг өөрөөр нэрлэж болно. Тухайн оронд нэрвэгдсэн газарт тусламж, үйлчилгээгээ үзүүлэх ямар ч байгууллага, хувь хүн, донор байгууллагууд нэгдэх нь нээлттэй байдаг. Тухайн орны түвшинд кластерууд нь

- Хэрэгцээг тодорхойлж, дүн шинжилгээ хийх
- Яаралтай тусламжинд бэлтгэх
- Төлөвлөгөө, стратегийг боловсруулах
- Стандартыг хэрэгжүүлэх
- Мониторинг, тайлагнах
- Нөлөөллийн ажил хийх, нөөцийг хөдөлгөөнд оруулах
- Сургалт, чадавх бэхжүүлэх

зэрэг ажлуудыг үр дүнтэй, бүгдийг хамруулж зохицуулах хариуцлагыг хүлээнэ.

Кластер хандлага нь хямралтай байгаа газарт ажиллаж байгаа ХОТСЗ хөтөлбөртэй холбоотой байдаг. ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг хамруулдаг эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа, нийгмийн салбар гэх мэт хөгжлийн олон салбарт анхаарлаа хандуулдаг. ХОТСЗ хөтөлбөрийн үүрэг нь хямралын нөхцөлд байдалд өөр байдаггүй боловч ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг баталгаажуулахын тулд үндэсний, бүсийн, орон нутгийн хүмүүнлэгийн кластер салбар бүртэй хамтран ажиллах нь чухал. Кластер хандлага нь ХОТСЗ хөтөлбөрт хямралд байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах үйл ажиллагаа явуулахад нэмэлт нөөц эх үүсвэрийг (санхүүгийн болон техникийн) олох боломжийг олгодог.

Хүснэгт 1: Дэлхийн хүмүүнлэгийн кластерууд

Кластер/салбар	Холбогдох байгууллагууд
ТЕХНИКИЙН САЛБАРУУД:	
Эрүүл мэндийн кластер	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)
Хоол тэжээлийн кластер	НҮБ-ын Хүүхдийн Сан (ЮНИСЕФ)
Ус, ариун цэвэрийн кластер (WASH)	ЮНИСЕФ
Яаралтай үеийн орон байр, хоол хүнсний биш зүйлүүдийн кластер	Мөргөлдөөнт нөхцөл байдлын НҮБ-ын цагаачлагчдын дээд комиссар (UNHCR), Гамшгийн нөхцөл байдлын Олон улсын улаан загалмайн нийгэмлэг (IFRC)
Боловсролын кластер	ЮНИСЕФ, Хүүхдийг ивээх сан
Хөдөө аж ахуйн кластер	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO)
НИЙТЛЭГ ШИНЖТЭЙ САЛБАРУУД:	
Лагерийн зохицуулалт, менежментийн кластер	Мөргөлдөөнт нөхцөл байдлын НҮБ-ын цагаачлагчдын дээд комиссар(UNHCR), Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (IOM)
Хамгаалалтын кластер	Мөргөлдөөнт нөхцөл байдлын НҮБ-ын цагаачлагчдын дээд комиссар (UNHCR),
Сэргээн босголтын кластер	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP)
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД	
Логистикийн кластер	Дэлхийн Хүнсний хөтөлбөр (WFP)
Яаралтай үеийн теле харилцаа холбооны кластер	Хүмүүнлэгийн хэргийн зохицуулах офис (OCHA), ЮНИСЕФ, Дэлхийн Хүнсний хөтөлбөр (WFP)

Хямралаас хөгжил рүү шилжих нь

Хямралын үед гадаадын байгууллагуудын цутгалан болдог. Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өмнө байдгаасаа илүү сайн үйлчилгээг авах тохиолдол ч гардаг. Хөгжлийн бэрхшээл нь удаан хугацааны хөгжлийн асуудал байдаг. Тиймээс тэдгээр гадаадын байгууллагууд нэгэн цагт тухайн нутгаас гарч явахад үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, тогтворттой хөгжүүлэх чадавхтай үлдэхийн тулд гадаадын байгууллагууд тухайн хамт олонтой түншилж ажиллах нь чухал байдаг. Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх стратегитай ХОТСЗ хөтөлбөр нь голлох үүргийг гүйцэтэх ёстой.

Санал болгож буй үйл ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудын гурван үндсэн салбарт хуваан санал болгож байна: бэлтгэх (гарах үр нөлөөг багасгахын тулд хямралын өмнө хийх үйл ажиллагаа, арга хэмжээ), яаралтай үеийн хариу үйлдэл (амь аврах, хямралд өртсөн хүмүүсийн үндсэн хэрэгцээг хангахад тусламж үзүүлэх), сэргээн босголт (хямралын өмнө байсан амьдралын хуучин нөхцөл байдлыг сайжруулах, сэргээх).

Гарч болох хямралд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бэлтгэ

ХОТСЗ хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдний гэр бүлийн гишүүд, хамт олныг байгалийн гамшиг гэх мэт гарч болох хямралд бэлтгэх олон үйл ажиллагаанууд байдаг. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бэлтгэх үйл ажиллагаанд оролцуулахын чухлын талаар хамт олны ойлголтыг нэмэгдүүлэх. Тухайлбал: Орон нутгийн мэргэжилтнүүд, Гамшгийн менежментийн хороо, яаралтай тусламжийн ажилтнууд болон бусад хамт олны гишүүдэд хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бэлэн байдлын талаарх ажлын төлөвлөгөөний явцын талаар мэдээлэл өгч, тэдний гамшгийн менежментийн хороонд орохыг нь дэмжих;
- Тухайн газар нутагт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг илрүүлж, бүртгэж, хаана амьдарч байгаа болон хямралын нөхцөлд тэдний хэрэгцээний талаар тэмдэглэх;
- Тоо, мэдээллийнхээ хувийг өөр газар (төв байгууллага эсвэл түншлэгч байгууллага дээр) хадгалж байх хэрэгтэй. Хямралын үеэр мэдээлэл үргэлж алдагддаг;

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бэлэн байдлын талаарх үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, нүүлгэн шилжүүлэх дасгал, сургуулилт хийхэд тэднийг оролцохыг дэмжих;
- Бэлэн байдлын арга хэмжээг хүртээмжтэй байлгах талаар холбогдох гол хүмүүст зөвлөгөө өгөх. Тухайлбал, анхааруулах систем, нүүлгэн шилжүүлэх процедур, яаралтай үеийн орогнох газар гэх мэт;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг бэлэн байдлын арга хэмжээг гэртээ бэлтгэхийг дэмжих:

–Яаралтай тусламжийн үед дэмжлэг үзүүлэх итгэлтэй хүмүүсийг илрүүлэх;

–Уналт, таталтын эм, тоног төхөөрөмж/материал (нуруу нугасны гэмтэлтэй хүмүүст зориулсан шээсний сав, туслах хэрэгсэл гэх мэт) зэрэг зайлшгүй хэрэгцээтэй эм, хэрэгслийг илүү хэмжээгээр хадгалах;

–Эм, харилцааны хэрэгцээ гэх мэт хувь хүний хэрэгцээний талаарх мэдээллийг гаргах;

–Нүүлгэн шилжүүлэх процедураар дадлага хийх. Тухайлбал, Нүүлгэн шилжүүлж түр орогнох байранд хүргэж өгөх.

Яаралтай тусламжийн үеийн хариу үйлдэлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруул

Тухайн үеийн нөхцөл байдлыг мэд

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээллийн санг дахин шинэчилж, яаралтай үед хэрэглэх бүх холбогдох хүмүүст бэлэн байлга.
- Хямралаас өмнөх үйлчилгээнүүдийг ашиглахад бэлэн эсэхийг тодорхойл.

Шинэ хүмүүстэй түншлэл тогтоо

- Хамт олон дотор байгаа шинэ хүмүүсийг илрүүлж, холбоо тогтоо.
- Тэдний үүрэг, хариуцлагыг тодорхойлж, тэдний үзүүлж чадах үйлчилгээ, нөөц бололцоог тодорхойл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн одоогийн нөхцөл байдлын талаарх мэдээллээ хуваалц.
- Хамт олны, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг судалж, дүн шинжилгээ хийхэд нь тусал.
- Хамт олны, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чадавхийг судалж, дүн шинжилгээ хийхэд нь тусал.
- Дэд бүтэц, хүний нөөц, түншлэгч нар болон үйл ажиллагаа гэх мэт ХОТСЗ хөтөлбөрийн чадавхийн талаарх мэдээллийг өг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үйлчилгээ, дэмжлэг туслалцаатэй хялбархан холбох илгээх механизмыг бий болго.
- ХОТСЗ хөтөлбөрийн боломжит үйл ажиллагаануудын тадаар тэдэнтэй ярилцаж, холбогдох кластер/салбараар дамжуулж нөөц бололцоог хэрхэн хүртээмжтэй болгох талаар санал дэвшүүл.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд мэдээлэл сайн олго

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тухайн нөхцөл байдлын талаар мэдээллийг сайн олгох.
- Боломжтой бол, хөгжлийн бэрхшээл, тэдний гэр бүлийн гишүүдэд тусламжийн үйл ажиллагаа болон бэлэн байгаа дэмжлэгийн талаар мэдээллийг олгох газрыг хүртээмжтэй газарт зохион байгуулах.
- Гол мэдээлэл/мессежийг явуулахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулах.
- Бүх мэдээлэл, харилцааны аргууд нь хүртээмжтэй байх ёстой.

Холбогдох кластер/салбарт хийж болох үйл ажиллагаа

ХОТСЗ хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдтэй хамтарч орон нутгийн, үндэсний болон олон улсын бүх холбогдох гол хүмүүсийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд анхаарлаа хандуулж, хүмүүнлэгийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд хамруулж чадна. ХОТСЗ хөтөлбөрийн хийж болох зарим үйл ажиллагаануудыг холбогдох кластер/салбаруудаар санал болгож байна.

Эрүүл мэндийн кластер/салбар

- Эрүүл мэндийн үйлчилгээ (гэмтэл, анхны тусламж) хэнд нэн тэргүүнд хэрэгцээтэй байгааг олж, тохирох үйлчилгээнд илгээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хувийн туслалцаа хэрэгтэй бол тэднийг эрүүл мэндийн үйлчилгээнд хүргэж өг.
- Туслах хэрэгсэл нь алга болсон/эвдэрсэн хэмхэрсэн бол түүнийг нь орлуулж өгч, харин шинээр осол гэмтэл авсан, эмгэг согогтой байгаа хүнд шинээр олго.
- Гэмтсэн болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үндсэн тусламж үйлчилгээ үзүүлж, түүнийг нь хянаж, мөн сэргээн засалтанд хамруул.

Хоол тэжээл, логистикийн кластер/салбар

- Хоол хүнс тараах явцыг хүртээмжтэй болгох талаар хүмүүнлэгийн ажилтнуудад зөвлөгөө өгч, тусал. Жишээ нь тусад нь дугаарлуулах, түгээх тусгай газар бий болгох, тэрхүү газарт налуу зам хийх гэх мэт.
- Хоол хүнс хэрэгтэй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өгч байгаа хоол хүнсний норм нь олдоцтой байгаа эсэхийг баталгаажуул. Тухайлбал, зажлах эсвэл залгих бэрхшээлтэй байгаа хүмүүс зориулан нухахад амархан хоол хүнс, эсвэл нухаш өгөх.

Яаралтай үеийн түр орогнох байр болон хоол хүнсний биш зүйлүүдийн кластер/салбар

- Түр орогнох байрыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах талаар хүмүүнлэгийн ажилтнуудад зөвлөгөө өгч, тусал.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөнжил, брезент, ариун цэврийн хэрэгсэл, хувцас зэргийг олдоцтой байгаа эсэхийг баталгаажуулж хүмүүнлэгийн ажилтнуудад зөвлөгөө өгч, тусал.
- Шаардлагатай үед нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд хэрэгслүүдийг нь шууд аваачиж өг.

Угаалгын кластер/салбар

- Түр зуурын бие засах газрыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиромжтой байлгах талаар хүмүүнлэгийн ажилтнуудад зөвлөгөө өгч, тусал.
- Ус түгээх цэг, гар насос, худаг зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах талаар хүмүүнлэгийн ажилтнуудад зөвлөгөө өгч, тусал.
- Усны эх үүсвэр, ариун цэврийн өрөө зэрэг нь хэзээ, хаана байгаа талаарх мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд өг.
- Ус болон ариун цэвэртэй холбоотой өвчнөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг хүртээмжтэй форматаар гарга.

Боловсролын кластер/салбар

- Боловсролын хөтөлбөрүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамарсан байх ёстой.
- Үйл ажиллагаандаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулах аргуудыг багшид зааж, тусалж дэмж.

Хамгаалалтын кластер/салбар

- Оюун ухааны хомсдолтой хүмүүс болон хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийг хүчирхийлэл, дарамт, ялгаварлан гадуурхалтаас хамгаалах зэрэг хөгжлийн бэрхшээлийн талаарх бүх хүмүүнлэгийн ажилтнуудын ойлголтыг нэмэгдүүл.
- Түр орогнох байранд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аль болохоор авулгүй нөхцөл байдлыг бүрдүүлэх талаар хүмүүнлэгийн ажилтнуудад зөвлөгөө өгч, тусал. Тухайлбал, аюултай газарт хашаа барих, гэрэлтүүлгийг хангалттай болгох, гэр бүл, асран хамгаалагчтай аль болох хурдан уулзуулах гэх мэт.
- Хүүхдэд ээлтэй орон зайг олж, хүүхэл хамгааллын арга хэмжээнүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулах.
- Ижил бэрхшээлтэй хүмүүс бусад ижил бэрхшээлтэй хүндээ туслах, зөвлөх үйл ажиллагааг хөгжүүлж, өөрөө өөртөө туслах бүлэг байгуулахыг нь дэмж (Эрх мэдэлжүүлэх бүрэлдэхүүн хэсэг товхимол: Өөрөө өөртөө туслах бүлэг хэсгийг уншина уу)
- Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд хүртээмжтэй болгож, тэдний хамруулах.

Сэргээн босголт, хөдөө аж ахуй болон хамгаалалтын кластер/салбар

- Хүмүүсийн өөртөө найдах байдлыг сайжруулах зорилгоор амьжиргааны арга хэрэгслүүдээр (багаж хэрэгсэл, эхлэх хөрөнгө гэх мэт) хангах

Сэргээн босголтын үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст амьдралынхаа чанарыг сайжруулах, сэргээхэд нь туслах

Хямралт нөхцөл байдал тогтворжоод ирмэгц дэд бүтцээ аажмаар дахин сэргээж, үйлчилгээнүүдийг явдаг зарчмаар нь үзүүлж эхэлдэг. Хямрал хөгжлийн шинэ боломжийг бий болгодог, “дахин сэргээсэн” хамруулсан хамт олонг үүсгэхэд ХОТСЗ хөтөлбөр эдгээр боломжуудыг давуу талаа болгох хэрэгтэй. ХОТСЗ хөтөлбөр дараах зүйлүүдийг хийхийг санал болгож байна.

- Орон нутгийн удирдлагууд болон бусад хөгжлийн байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн хэрэгцээ, хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээлэл өгөх ажлаа үргэлжлүүлэх.
- Дахин сэргээн босоход оролцож байгаа гол хүмүүст орон байр, ус, ариун цэвэр, сургууль, нийтийн барилга, тээвэр гэх мэт хүртээмжийн асуудлуудын талаар мэдээлэл өгөх. Тухайлбал хамгийн наад захын хэрэгцээг хангах стандарт, практик зааварчилгаа, сайн жишээ, түгээмэл загварын арчим зэрэг нь ашигтай байж болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд нь буцаан оруулахын тулд боловсролын салбартай хамтран ажиллах (Боловсрол бүрэлдэхүүн хэсэг товхимолыг уншина уу). Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн

гишүүдийг өмнөх амьжиргааныхаа үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд, шаардлагатай бол амьжиргааны шинэ боломжуудыг олж илрүүлэхэд туслахын тулд холбогдох гол хүмүүстэй хамтран ажиллах (Амьжиргаа бүрэлдэхүүн хэсэг товхимолыг уншина уу).

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд гэр бүл, найз нөхдийнхөө харилцааг дахин сэргээх, хамт олны үйл ажиллагаанд оролцох боломжтой болгохын тулд шаардлагатай нийгмийн дэмжлэг тусламжийг авахад холбогдох гол хүмүүстэй хамтран ажиллах (Нийгмийн бүрэлдэхүүн хэсэг товхимолыг уншина уу).
- Хямралын нөхцөл байдлыг даван туулсан хүмүүсийн байгуулсан өөрөө өөртөө туслах бүлгийг дэмж (Эрх мэдэлжүүлэх бүрэлдэхүүн хэсэг товхимолын Өөрөө өөртөө туслах бүлэг хэсгийг уншина уу)

Жишээ 22

Хоршоогоор дамжуулж хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгосон нь

Индонезид болсон гамшигт газар хөдлөлтийн дараа олон хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй болж, гэмтлийн дараах стресс, эмгэг үүсч, орлогоо алдсан юм. Тэд хамтарч энэхүү нөхцөл байдлаасаа гарахаар шийджээ. ХОТСЗ хөтөлбөрийн тусламжтгайгаар тэд хоршоо байгуулав. Засгийн газрын бус байгууллага тэдэнд санхүүгийн болон техникийн тусламж үзүүлэв. Хоршоо нь тоосго үйлдвэрлэдэг, хувцас үйлдвэрлэл, хоол хүнс зардаг гэх мэт үйлдвэрлэл эрхэлдэг өөрсдийнхөө гишүүддээ зээл олгож, бизнесийн зөвлөгөө өгөв. Хоршоо үйл ажиллагаагаа аажмаар тэлж, ажлын боломжуудыг олгосноор гишүүдийн орлого нэмэгдэв.

Ашигласан материалууд

- Inter-agency fi eld manual on reproductive health in humanitarian settings. Inter-agency Working Group on Reproductive Health in Crises, 2010 (www.iawg.net/IAFM%202010.pdf, accessed 30 March 2010).
- Disaster statistics 1991–2005. United Nations International Strategy for Disaster Reduction (ISDR), 2006 (www.unisdr.org/disaster-statistics/introduction.htm, accessed 30 March 2010).
- Disasters, disability and rehabilitation. World Health Organization, 2005 (www.who.int/violence_injury_prevention/other_injury/en/disaster_disability.pdf, accessed 30 March 2010).
- Adapted from: CBM (undated) (www.cbm.org/en/general/CBM_EV_EN_general_article_75271.html,accessed 30 March 2010).
- Humanitarian charter and minimum standards in disaster response. Sphere Project, 2004 (www.sphereproject.org/content/view/27/84, accessed 15 June 2010).
- Protecting persons aff ected by natural disasters – IASC operational guidelines on human rights and natural disasters. Inter-Agency Standing Committee (IASC), 2006 (www.brookings.edu/reports/2006/11_natural_disasters.aspx, accessed 30 March 2010).

- World disasters report 2007 – Focus on discrimination. International Federation of Red Cross andRed Crescent Societies (IFRC), 2007 (www.ifrc.org/publicat/wdr2007/summaries.asp, accessed15 June 2010).
- Disability and early tsunami relief efforts in India, Indonesia and Thailand. Center for International Rehabilitation/International Disability Rights Monitor, 2005 (www.idrmnet.org/reports.cfm, accessed 30 March 2010).
- Kett M et al., for International Disability and Development Consortium. Disability in conflict and emergency situations: focus on tsunami-affected areas. 2005 (www.iddcconsortium.net/joomla/index.php/conflict-and-emergencies/key resources, accessed 30 March 2010).
- Convention on the Rights of Persons with Disabilities. New York, United Nations, 2006 (http://www.un.org/disabilities/, accessed 30 March 2010).
- How to include disability issues in disaster management, following floods 2004 in Bangladesh. Handicap International, 2005 (www.handicap-international.fr/documentation-presse, accessed 30 March 2010).

Уншихыг зөвлөж буй материалууд

Accessibility for the disabled. A design manual for a barrier free environment. New York, United Nations, 2004
(www.un.org/esa/socdev/enable/designm/, accessed 30 March 2010).

Building an inclusive society. CBM, 2009
(www.cbm.org/en/general/downloads/48197/CBM_Profile_2009.
pdf, accessed 30 March 2010).

Disaster preparedness for people with disabilities, American Red Cross (undated)
(www.redcross.org/wwwfiles/
Documents/pdf/Preparedness/Fast%20Facts/Disaster_Preparedness_for_PwD-English.pdf, accessed
30 March 2010).

Disaster psychological response: handbook for community counsellor trainers. Geneva, Academy for
Disaster Management Education Planning and Training (ADEPT), 2005
(www.preventionweb.net/english/
professional/trainings-events/edu-materials/v.php?id=7708, accessed 30 March 2010).

E-discussion: disabled and other vulnerable people in natural disasters. Washington, DC, World Bank, 2006
(http://web.worldbank.org/WBSITE/EXTERNAL/TOPICS/EXTSOCIALPROTECTION/EXTDISABILITY/0,,cont
entMDK:20922http://web.worldbank.org/WBSITE/EXTERNAL/TOPICS/EXTSOCIALPROTECTION/EXTDISA
BILITY/0,,contentMDK:20922979~pagePK:210058~piPK:210062~theSitePK:282699,00.html, accessed 30
March 2010).

Guidance note on using the cluster approach to strengthen humanitarian response. Inter-agency Standing
Committee (IASC), 2006
(www.humanitarianreform.org/humanitarianreform/Portals/1/Resources%20
&%20tools/IASCGUIDANCENOTECLUSTERAPPROACH.pdf, accessed 30 March 2010).

Health cluster guide: a practical guide for country-level implementation of the health cluster. Geneva, World Health Organization, 2009 (www.who.int/hac/global_health_cluster/guide/en/index.html, accessed 30 March 2010).

Hyogo framework for action 2005–2015. Geneva, International Strategy for Disaster Reduction, 2005 (www.unisdr.org/eng/hfa/hfa.htm, accessed 30 March 2010).

Older people in disasters and humanitarian crises: Guidelines for best practice. HelpAge International, 2005 (www.helpage.org/Resources/Manuals, accessed 30 March 2010).

Older people's associations in community disaster risk reduction. HelpAge International, 2007 (www.helpage.org/Resources/Manuals, accessed 30 March 2010).

Oxfam GB/Emergency Capacity Building Project. Impact, measurement and accountability in emergencies: the good enough guide. Oxfam, Oxfam GB, 2007 (http://publications.oxfam.org.uk/oxfam/display.asp?isbn=0855985941, accessed 30 March 2010).

Promoting access to the built environment – guidelines. CBM, 2008 (www.cbm.org.au/documents/Be%20Active/Access%20to%20built%20environment%20guidlines%20-%20CBM.pdf, accessed 30 March 2010).

Scherrer V. Disability in emergency: accessing general assistance and addressing specific needs. Voice Out Loud Newsletter, No.5, May 2007 (http://60gp.ovh.net/~ngovoice/documents/VOICE%20out%20loud%205_final.pdf, accessed 30 March 2010).

Scherrer V et al. Towards a disability-inclusive emergency response: saving lives and livelihoods for development. Journal for Disability and International Development, 2006,1:3–21 (www.ineesite.org/toolkit/docs/Journal_for_Disability_MSEE.pdf, accessed 30 March 2010).

cBr

•

ХОТСЗ ХАНДЛАГЫН МАТРИЦ